

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.12.04

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Тэргүүлэгчид 11 дүгээр сард 2 удаа хуралдаж 20 гаруй асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

-Хуралдаан зарлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 12-р хуралдааныг 2018 оны 12-р сарын 05-ны өдөр хуралдуулж аймгийн 2019 оны төсвийн төсөл, зарим тосгодыг сум болгох санал уламжлах тухай асуудлыг хэлэлцэхээр тогтож, Хүүхэд ээлтэй бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл, “Халдварт бус өвчинтэй тэмцэх” аймгийн хөтөлбөрийн төслийг хэлэлцэн баталж, “Архидалттай тэмцэх аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, үр дүн, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлэг, лабораториудын үйл ажиллагааны талаар болон аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын талаарх Алтанбулаг, Шаамар сумын Засаг дарга нарын мэдээллийг сонсож, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны орон тоог шинэчлэн тогтоов.

Мөн үндсэн хөрөнгийг актлах, үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгө актлаж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай болон Мандал сумын “Амьд чулуу”, Сайхан сумын “Хөтөл адвентист” сүмүүдийн зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгахаар шийдвэрлэж, Мандал сумын Хэрх тосгоны цэцэрлэгийн 60 жилийн ой, Баянгол сумын цэцэрлэгийн 50 жилийн ой, Мандал сумын “Цант-Орхон” ОНӨААТҮГ-ын 20 жилийн ойг тэмдэглэх зөвшөөрлийг тус тус олголоо.

Тус аймгийн харъяат иргэн Рэнцэнгийн Дарамбазарыг МУ-ын Гавьяат тээвэрчин цолоор шагнуулах болон зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар шийдвэрлэлээ.

**2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Энэ онд аймгийн хэмжээнд үр тариа 170,5 мянган га талбайгаас 211,5 мянган тонн, улаанбуудай 175 мянган тонн, бусад үр тариа 5,8 мянган тонн, рапс 11,6 мянган тонн, тэжээлийн ургамал 18,6 мянган тонн, төмс 32,1 мянган тонн, хүнсний ногоо 31,5 мянган тонныг хураан авсан бөгөөд ургац хураалтын эцсийн мэдээг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүллээ.

2018-2019 онд аймгийн хэмжээнд 1551548 мянган толгой мал өвөлжих дүн мэдээтэй байна. Үүнээс тэмээ 499, адуу 95931, үхэр 215485, хонь 725095, ямаа 514537, толгой байна. Малчдын түвшинд 149684 тонн байгалийн хадлан, 13470 тонн сүрэл, 13470 тонн ногоон тэжээл, 206335 тонн үйлдвэрийн тэжээл, 633 тонн гар тэжээл, 6097 тонн дарш, 8283 тонн давс хужирыг бэлтгэсэн бөгөөд 106 хувиар биелүүлсэн дүнтэй байна. Малчид, баг, сум, аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд “Хадлан тэжээл-2018” болзолт уралдааныг зарлан дүгнэсэн бөгөөд сумын дүнгээр Орхонтуул сум шалгарлаа.

Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс 150 тонн, тэжээл 50 тонныг бэлтгээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шаамар, Орхон, Сайхан сумдад инженерийн хийцтэй уст цэг гаргах ажлыг “Булган ус” ХХК гүйцэтгэж, сумдад нь хүлээлгэн өгөөд байна.

“Удирдах ажилтны мэдээллийн цаг” арга хэмжээ 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр боллоо. Арга хэмжээнд сум, агентлагийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг нар оролцуулан өргөтгөтгөсөн байдлаар зохион байгуулагдаж, Улсын хэмжээнд зохион байгуулж буй төрийн жинхэнэ албан хаагчдын

үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлын талаар аймгийн Засаг дарга үүрэг чиглэл өгснөөс гадна Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгасан тухай Цагдаагийн газрын дарга А.Энхбат, Тагнуулын газрын дарга Б.Алтангэрэл, Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа нар мэдээлэл хийж, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажилд бэлтгэх, анхаарах асуудлуудын талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа, “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ёндонжамц нар мэдээлэл өглөө. Энэ үеэр аймгийн Засаг дарга “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл”-д зөөврийн компьютер өгч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатраар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт 11-р сарын 15-20-ны өдрүүдэд тус аймагт ажиллалаа. Энэ ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэх тестийн шалгалтыг 807 төрийн албан хаагч хамрагдсан.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил БНСУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд CHUNG JAE NAM тэргүүтэй төлөөлөгчдийг 10-р сарын 31-ний өдөр хүлээн авч уулзлаа. Элчин сайдыг БНСУ-ын Элчин сайдын яамны 1-р нарийн бичгийн дарга Park Heon, Батлан хамгаалахын атааше Kim Hun Sang, консул Jung Hyun Gu, консул Kil Kang Muk, Koica байгууллагын орлогч дарга Woo Dong Wan, Koica байгууллагын суурин төлөөлөгч Choi Man Young нарын албаны хүмүүс дагалдан ирсэн бөгөөд аймгийн Засаг даргаас “Koica” байгууллагатай архивын хадгалалт хамгаалалтын асуудлыг шийдвэрлэхэд хамтарч ажиллах хүсэлтээ илэрхийллээ.

### **Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар:**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Авто үйлчилгээний байгууллага”-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн хүрээнд хяналт шалгалт явуулах төлөвлөгөө гарган, гамшгаас хамгаалах тухай болон галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдалд нь үнэлгээ, дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулж, төлөвлөгөөт шалгалтад Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт 11 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд хийж 69 зөрчлийг илрүүлж гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 10, мэдэгдэл 1-ийг үйлдэж байгууллагын дарга, эрхлэгч нарт өгч ажиллалаа.

Мэдээг нэгтгэвэл:

Шалгалтанд хамрагдсан объектын тоо	Зөрчил		Захиргааны арга хэмжээ		Заавал биелүүлэх албан шаардлагын тоо	Албан мэдэгдлийн тоо	Танилцуулгын тоо	Ажиллагаа зогсоох тогтоолын тоо	Сургалт, дадлага, зааварчилгааны тоо Хүн/цаг	Хэвлэл мэдээлээр сурталчилсан тоо
	Илэрүүлсэн зөрчлийн тоо	Шалгалтын явцад ариллуулсан зөрчлийн тоо	Арга хэмжээ авагдсан объектын тоо	Торгуулийн хэмжээ /тегрөгөөр/						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
11	69	13	-	-	10	1	-	-	21 ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн	-

### **Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:**

Тайлант сард Сүхбаатар, Хүдэр, Мандал, Сайхан, Хушаат, Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Орхон, Цагааннуур, Шаамар, Зүүнбүрэн сумдын 45 аж ахуйн нэгж, иргэний 19 хүнсний дэлгүүр, 9 минимаркет, 3 зоогийн газар, 6 караоке баар, 2 кафе, 2 цайны газар, 1 хүнсний мухлаг, 1 үсчин, 1 халуун усны газар, 1 дэн буудлын үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 36 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Алтанбулаг сумын иргэн Д.Баярзулын үйлдвэрлэсэн чацарганы жүүс, Сайхан сумын Номгон тосгоны иргэн Д.Баярсайханы үйлдвэрлэсэн бор еэвэнд тохирлын гэрчилгээ олгож, Сайхан сумын “Хөтөл Дээжис” цехийн үйлдвэрлэсэн бялуу, кекс, Шаамар сумын иргэн Д.Мягмар, Сүхбаатар сумын 5-р багт байрлах “Сэ Тэ Би” ХХК-ий үйлдвэрлэсэн зөгийн балыг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өглөө. Мөн 6 өрхийн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй 5 нэрийн бүтээгдэхүүний хаяг шошгыг хянаж холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах талаар зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Стандартын салбар сангаас 4 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 12 нэрийн 12 стандартаар хангаж, аргазүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс 2 аж ахуй нэгж байгууллагад 10 нэрийн 10 стандартын борлуулалт хийсэн байна.

Аймгийн 15 сумдад ажиллаж тайлангийн хугацаанд 21 шатахуун түгээх газрын 180 түгээгүүрийн шингэн хэмжигчийг ээлжит баталгаажуулалтад хамруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. “НИК” ХХК-ний инженер, техникийн ажилтнуудтай хамтран тухайн компаний харьяа ШТС-ын хэмжих хэрэгслийг баталгаажуулах ажлыг хамтран гүйцэтгэлээ.

Хүнсний захуудад сүү цагаан идээ борлуулдаг 6 иргэдийн хэмжээт савыг шалган баталгаажууллаа. 3 аж ахуйн нэгжийн усны тоолуурыг шалган 2 нь шаардлага хангасан тул баталгаажуулалтын гэрчилгээ олгож, 1 тоолуур шаардлага хангаагүй тул ашиглахгүй тухай мэдэгдэл хүргүүлсэн.

Механик хэмжлийн төрлөөр Мандал, Баянгол, Сайхан, Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур, Шаамар сумдад ажиллаж худалдаа, үйлчилгээний газрын 152 жин, 30 туухайг, дулаан даралтын төрлөөр эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 4 термометр, уурын зуухны 2 термометрыг, цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын айл өрхийн 4 ш цахилгааны 1 фазын тоолуур шалган ээлжит бус баталгаажуулалт хийлээ.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

2017 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, төрийн сангийн тогтолцоо, үр дүнд хийсэн аудитын шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөөний дагуу өмнөх зөрчил дутагдлыг давтахгүй арилгах, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй гаргах зорилгын хүрээнд Ерөө-Сайхан, Сүхбаатар-Мандал, Баянгол-Цагааннуур, Хүдэр-Түшиг, Баруунбүрэн-Зүүнбүрэн, Шаамар-Сант, Орхонтуул-Жавхлант, Алтанбулаг-Хушаат, Орхон-Баруунбүрэн сумдууд удирдамжийн дагуу үйл ажиллагааг шалган, зөвлөн тусалж, харилцан туршлага солилцон ажиллалаа. Сумдын санхүүгийн ажилтнууд ажлын байран дээр бие биеээсээ суралцах, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх боломжийг бий болгосон үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Жавхлант, Баянгол сумын Санхүүгийн албанд шинээр томилогдсон төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдэд энэ сарын 27-28-ны өдрүүдэд ажлын байрны дадлага сургалтад хамрууллаа.

## 1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>68,181,561,1</b>	<b>65,095,470,3</b>	<b>95,5</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>15,270,539,5</b>	<b>14,415,314,2</b>	<b>94,4</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11,734,882,2	10,365,021,0	88,3
	Сумдын төсвийн орлого	3,535,657,3	4,050,293,1	114,6
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	5,750,000,0	5,750,000,0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	38,839,528,7	38,839,528,7	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3,186,673,9	3,186,673,9	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	2,761,970,3	2,761,970,3	100,0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	141,983,2	141,983,2	100.0
1,7	Төсөвт байгууллагын өөрийн орлого /сум хөгжүүлэх сан орсон/	2,230,865,5	1,277,544,0	57,3
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>68,181,561,1</b>	<b>60,726,324,7</b>	<b>89,1</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>68,181,561,1</b>	<b>60,726,324,7</b>	<b>89,1</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	9,636,282,1	8,703,885,8	90,3
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2,929,902,8	1,199,021,6	40,9
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага</b>	<b>17,062,498,4</b>	<b>13,973,050,7</b>	<b>81,9</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	3,032,394,1	1,917,626,5	63,2
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	488,376,0	271,214,5	55,5
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2,074,278,8	1,187,427,7	57,2
	Халамжийн сан	7,755,164,7	7,240,193,1	93,4
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	3,449,061,0	3,099,816,9	89,9
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	263,223,8	256,771,9	97,5
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	36,201,271,0	34,713,485,8	95,9
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	2,351,606,8	2,136,880,9	90,9
	<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>45,647,451,7</b>	<b>45,647,451,7</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,036,001,9	4,036,001,9	100.0
3.2	<b>Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>1,912,175,6</b>	<b>1,912,175,6</b>	<b>100.0</b>
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	109,441,0	109,441,0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	317,657,5	317,657,5	100.0
	Хөрөнгө оруулалтын зардалд	1,485,077,1	1,485,077,1	100.0
3.3	<b>Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>1,274,498,3</b>	<b>1,274,498,3</b>	<b>100.0</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1,271,290,5	1,271,290,5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	3,207,8	3,207,8	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	36,125,314,1	36,125,314,1	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	2,299,461,8	2,299,461,8	100.0
3.6	<b>Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/</b>	<b>38,424,775,9</b>	<b>38,424,775,9</b>	<b>100.0</b>
	- Ерөнхий боловсролын сургууль	19,544,478,4	19,544,478,4	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	9,898,239,6	9,898,239,6	100.0
	- Соёлын байгууллага	2,532,039,5	2,532,039,5	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	894,549,1	894,549,1	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	4,907,072,3	4,907,072,3	100.0

	- Газрын кадастрын байгууллага	331,575,6	331,575,6	100.0
	- Хүүхдийн байгууллага	316,821,4	316,821,4	100.0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>1,843,142,2</b>	<b>565,822,4</b>	<b>30,7</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,843,142,2	565,822,4	30,7

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 IX- сар	2018 X- сар	<u>2018- X</u> <u>2018-</u> IX/төгрөгөөр /
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	5500	6000	109.1
	Үхрийн мах /кг/	6500	6 500	100.0
	Адууны мах /кг/	5800	5800	100.0
	Ямааны мах /кг/	5 500	5 500	100.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	900	1 000	111.1
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	1 200	1 200	100,0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	800	1000	125.0
	Лууван /кг/	1000	1200	120.0
	Манжин /кг/	1000	1200	120.0
	Байцаа /кг/	1000	1500	150.0
	Сонгино /кг/	1200	1500	125.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 645	1 745	106.1
	Бензин А - 92	1 795	1 885	105.0
	Дизелийн түлш	2 105	2 245	106.7

## **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 10 сард 459 холбогдогчтой, 1455.5 сая төгрөгийн хохиролтой, 652 гэмт хэрэг бүртгэгдэж 7 хэргээр буюу 1.1 хувиар урьд оны мөн үеэс өсч, гэмт хэргийн илрүүлэлт 47.6 хувьтай, 19038 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь 102 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 0.5 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 11 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 261 бичиж, лавлагаа 7, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 586, лавлагаа 21 олгосон.

Иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэлд 234, гэрлэлтийн бүртгэл 61, гэрлэлт цуцалсны бүртгэл 22, үрчлэлт 6, эцэг тогтоолт 16, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 17, нас баралтын бүртгэл 73-ыг хийж, 737 иргэнд иргэний үнэмлэх олгож, иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан 380 иргэнд олгож, 66 иргэнд гадаад паспорт олгох үйлчилгээ үзүүлж, аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан 63, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 113, хот доторх шилжилт хөдөлгөөн 303 тус тус бүртгэгдсэн байна.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Төрийн албаны тухай” шинэчилсэн найруулга, “Цахим гэмт хэрэг”, “Зөрчлийн тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай”, “Хоршооны эрх зүйн зохицуулат” зэрэг сэдвүүдээр давхардсан тоогоор 1120 иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн албан болон албан бус сургалт зохион байгууллаа.

## **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:**

Боловсролын салбарын удирдах ажилтнуудыг “Багшийн хөгжил, байгууллагын менежмент” сэдэвт сургалт, монгол хэл бичиг, уран зохиол, биологийн багш нарыг заах арга, ур чадварыг дээшлүүлэх сургалт, “Хөдөөгийн суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээллийн технологийг оновчтой ашиглах” төслийн хүрээнд сургагч багш бэлтгэх бүсчилсэн сургалт, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд БМДИ-тэй хамтран “БАГА АНГИЙН СУРАГЧДЫН ЭХ ХЭЛНИЙ АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ, УНШИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, Сүхбаатар, Шаамар сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирлуудыг "ЕБС-д хүний эрхийн боловсрол олгож буй сайн туршлага" цахим хэлэлцүүлэгт орууллаа. 5 багшид мэргэжлийн зэрэг олгох, 13 кабинетад гэрчилгээ олгох хүсэлтэд дүгнэлт гаргаж, төрийн албан хаагчдын удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийн явцад үнэлгээ, зөвлөгөөг өгч ажиллалаа.

Япон Улсын Засгийн Газраас зарласан “XXI зууны зүүн Азийн хүүхэд, залуусын өргөн харилцааны хөтөлбөр” /JENESYS/-ийн шаардлагыг хангасан Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сурагч Т.Халиуныг хамруулах саналаа БСШУСЯ-нд хүргүүлээ.

“Хүүхдийн хөгжилд-Эцэг эхийн оролцоо” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, сургуулийн захирал, эцэг эхийн зөвлөлийн дарга, дотуур байранд сууж байгаа хүүхэдтэй эцэг эхийн төлөөлөл, төрийн албан хаагч эцэг эхийн төлөөлөл, зорилтот бүлгийн /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэдтэй эцэг эхийн төлөөлөл, бусад эцэг эхийн төлөөлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй, цэцэрлэгүүдээс цэцэрлэгийн эрхлэгч, эцэг эхийн зөвлөлийн дарга, эцэг эхийн төлөөлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй, нийт 320 гаруй хүнийг хамруулж, оролцогч талууд зөвлөмжийг хэлэлцэн баталж, амжилт гаргасан сургууль, цэцэрлэгүүдийн эцэг эхийн зөвлөлийг шагнаж урамшууллаа.

“Багш сурагч” солилцоо хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн лаборатори 4, Цагааннуур сумын сургуулиудын бага ангийн багш нар харилцан ажлын туршлага солилцож, арга зүй, сургуулийн туршлагаа түгээв.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны А/372 тоот захирамжаар байгуулагдсан “Хамтарсан хяналт, шинжилгээний ажил”-ын баг Сүхбаатар сумын

ерөнхий боловсролын 2 сургууль, 2 цэцэрлэгийн боловсролын салбарын мэдээллийн системд анхан шатны бүртгэл, статистик мэдээ, тархаалт хийсэн байдал дээр хамтарсан хяналт шинжилгээ үнэлгээг хийж зөвлөн тусаллаа.

БНСУ-ын Жэжү тусгай мужид зохион байгуулагддаг Олон Улсын Хүүхэд Залуучуудын 9-р форумд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 сурагч илтгэл хэлэлцүүлэн Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Орос хэл, соёлын төвийн бүсийн арга хэмжээнд 4 сурагч, 4 багш оролцсноос 1 сурагч 2-р байр эзлэн ОХУ-д тэтгэлгээр суралцах эрх, 2 багш олимпиадад 2, 3-р байр эзлэн ОХУ-д мэргэжил дээшлүүлэх эрхээр шагнууллаа.

БСШУСЯ, БОАЖЯ, ДБОБС, БОМСТ-өөс хамтран зохион байгуулсан “Эко сургууль хөтөлбөр”-ийн үндэсний 4-р чуулганаар Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль “НОГООН ТУГ”, Сүхбаатар сумын 1-р сургууль, Мандал сумын 3-р сургууль “МӨНГӨН ГЭРЭГЭ”, Шаамар, Ерөө, Сайхан, Сүхбаатар сумын 2-р сургуулиуд “ХҮРЭЛ ГЭРЭГЭ” хүртэж, тогтвортой хөгжлийн үзэл санаанд тулгуурласан ЭКО сургуулийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайлант үзэсгэлэн гаргаж туршлагаа түгээлээ.

Аймгийн ерөнхий боловсролын 31 сургууль дээр давхардсан тоогоор хүүхэд хөгжлийн 370 дугуйланд 11520 хүүхэд хамрагдаад байна.

УБТЗ-ын аварга шалгаруулах хойд бүсийн футзалын хөлбөмбөгийн тэмцээнд 9 байгууллага оролцож тэргүүн байранд “Шуудан алба”, дэд байранд “Т-3”, гутгаар байранд “Вохр” багууд шалгарч, шилдэг хаалгачаар н.Баясгалан, шилдэг хамгаалагчаар н.Батбуян, шилдэг тоглогчоор н.Даваасүрэн нар тодорлоо.

Хөдөлмөрийн хүндэт медальт Боловсролын тэргүүний ажилтан Н.Батболдын нэрэмжит жү-до бөхийн тэмцээнд 10 багийн 280 гаруй тамирчид эм -21, эр -27 жинд 3 насны ангиллаар өрсөлдөж, тэргүүн байранд “Шинэбадрах”, “Баянгол сум, дэд байранд Сант сум, “Шинэ бадрах”, гутгаар байранд Баянгол, Мандал сумдын багууд тус тус шалгарлаа.

Тэмцээнийг Монголын, аймгийн жүдо бөхийн холбоод, Баянгол сумын ИТХ, ЗДТГ хамтран зохион байгууллаа. Мөн тэмцээний үеэр “Шинэбадрах” дэвжээний захирал Д.Бадрах Баянгол сумын Алтан гадас одонт, Улсын тэргүүний ерөнхий боловсролын сургуульд дэвжээ бэлэглэлээ.

## **2. Эрүүл мэндийн талаар:**

“Эрүүл хүүхэд-Сэлэнгийн ирээдүй” аяны хүрээнд эрүүл мэндийн үзлэгийн 4 багийн 16 эмч, мэргэжилтнүүд Сүхбаатар сумын 8 цэцэрлэгийн 1400 гаруй хүүхдийг эрүүл мэндийн ерөнхий үзлэг, амны хөндий, чих, хамар хоолой, хөвгүүдийн эмчийн үзлэг, цагаан хорхойн шинжилгээнд хамруулж, цахим сан үүсгэн тэдний бие бялдрын өсөлт, хөгжилтийн түвшинг тогтоож, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад эцэг эх, багш нарыг бүрэн хамрууллаа.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газраас сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт чиглэл хүргүүлж, 2018 оны эхний 11 сарын байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг 71.9 хувь, чихрийн шижин хэв шинж 2-ийн эрт илрүүлэг үзлэг 64.9 хувь, хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг 51.4 хувь, элэгний эрт илрүүлэг үзлэг 55.6 хувьтай байна.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газраас Эрүүл мэндийн мэргэжлийн ангид гамшгийн үеийн бэлэн байдлын үзлэг шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар гамшгийн үеийн бэлэн байдлын үзлэг шалгалтад эрүүл мэндийн мэргэжлийн анги “Хангалттай сайн” үнэлгээг авлаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 16 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын баг Сүхбаатар сумын 5-р багийн 987 иргэдийг халдварт бус өвчний эрт илрүүлэг цогц үзлэг, оношилгоонд хамруулж, 648 иргэдийг цахим санд бүртгэн хяналтандаа авч эрүүлжүүлэх ажлыг эхлүүлээ.

### **3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 10 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн.Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал:

-Сэтгэл санааны дарамт- 2

-Бие махбодын хүчирхийлэл – 5

-Үл хайхрах хүчирхийлэл – 3

“МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ” өргөх ёслолын үйл ажиллагаанд 17 сумд, 6 тосгодын сурлага, урлаг, спортоороо манлайлагч шилдэг 100 сурагч оролцож, иргэний андгай өргөн “БАТЛАМЖ”, иргэний үнэмлэх дурсгалын зүйлс гардан авлаа.Аймгийн ИТХ, Засаг дарга тэргүүтэй удирдлагын баг оролцлоо.

Оюутан залуусын эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, эрүүл зан үйл, дадал төлөвшүүлэх зорилгоор “Эрүүл оюутан-хөгжлийн түүчээ” аяныг 17 сум 6 тосгонд өрнүүлж, нийт 1990 ахлах ангийн сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт, сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд 840 өсвөр насны сурагчдыг тус тус хамруулсан байна.

Гэрлэж буй 3 хосуудад “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт мэдээлэл хийж, гэр бүлийн тангараг өргүүлэн, гэрлэлтийн баталгаа гардуулах ажлыг “Хүндэтгэлийн танхим”-д зохион байгууллаа.

Швейцарын хөгжлийн агентлагаас санхүүжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-2030” төслийн үйл ажиллагааны үр дүнг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Сүхбаатар, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумд, Дулаанхаан тосгонд Хүүхэд хамгааллын баг нөхцөл байдлын үнэлгээ хийж, сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн ажил байдалтай танилцан арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Өдөр өнжүүлэх төвийн 4 багш, Мандал сумын 10 хамтарсан багийн 33 гишүүдийг ажлын байранд чадавхжуулах сургалт, Койка Олон улсын байгууллагын сайн дурын ажилтантай хамтран Сүхбаатар сумын 8 багийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эцэг эхчүүдийг хөгжлийн сургалтыг тус тус зохион байгууллаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтанд байгаа 6 хүүхэд, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 8 хүүхэд хууль эрх зүйн сургалтад хамруулж, эцэг эхчүүдтэй нь гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

### **4.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

2018 оны 10-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 731 байсан бол 435 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 173 ажлын байранд 161 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 274 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 731 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 11 сарын байдлаар 41.248 иргэнд 11.504.965 мянган төгрөгийг олгоод байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд Ерөө сумын Бугант тосгон, Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч, эцэг эх, анги удирдсан багш, нийгмийн ажилтан нийт 189 хүнд, “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалт, Жавхлант, Цагааннуур сумд, Дулаанхаан тосгоны хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насны ажилгүй 106 иргэдэд “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох”, “Харилцааны ур чадвар эзэмшүүлэх” сургалтыг тус тус зохион байгуулж, ажилд ороход хүндрэлтэй иргэдэд ганцаарчилсан зөвлөгөө өгч, ажилд ороход шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэх, ажил хайх арга замын талаар болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдэд талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

### **5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:**

Энэ оны 11 сарын байдлаар 26.8 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 28.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 105.3 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16380 тэтгэвэр авагчдад 53103.8 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 6374 хүнд 2381.29 сая төгрөгийг



хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 307 хүнд 1557.40 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 483 хүнд 758.69 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олголоо.

2018 оны 11 дүгээр сарын байдлаар шинээр 15 аж ахуйн нэгжийн 1174640,1 мянган төгрөгний нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг шүүхийн шийдвэр гаргуулан ажиллаж байна. Мөн 9 аж ахуйн нэгжийн 28843,0 мянган төгрөгний дансыг хааж, 5 аж ахуйн нэгжийн 13007,2 мянган төгрөгийн шимтгэлийн өрийг санд төвлөрүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 451 иргэд, даатгуулагчдад гарган түргэн шуурхай үйлчиллээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2018 оны 11 сард нийт 4 хурал хийж 311 хүнээс, 24 хүнийг цуцалж, 59 хүн шинээр тогтоолгосон, 228 хүн актаа сунгуулсан байна.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

“Адра Монгол” Олон Улсын байгууллагаас зохион байгуулсан “Органик хөдөө аж ахуйн суурь мэдлэг олгох сургалт”-нд төсөл хэрэгжих нийт 30 хоршоодын төлөөлөл 60 хүнийг хамруулсан.

“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналуудыг авч боловсруулан ХХААХҮЯ-нд хүргүүлээд байна.

Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг Монгол банкинд оруулахтай холбогдуулан сумдын мэргэжилтнүүд идэвхтэй ажиллаж, зээлдэгчдийн эргэн төлөлт сайжирч 11 сард хугацаа хэтэрсэн 62 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээд байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас явуулсан 10/4319 албан тоот албан бичгийн дагуу 2011-2013 онуудад ээмэгжүүлсэн малын тоо, 2018 онд захиалгын дагуу ээмэглэсэн талын тоо, мэдээллийн санд орсон малын тоо, ээмэглэсэн боловч мэдээллийн санд оруулаагүй малын тоо, мэдээллийн санд орсон малчин өрхийн тоог сумдаас авч нэгтгэн хүргүүлэв.

Алтанбулаг, Сүхбаатар, Баянгол, Мандал, Ерөө сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн, МЭАЦЛ-ийн нян судлалын шинжилгээнд 3 сумаас ирүүлсэн 6 цусанд ийлдэс судлалын шинжилгээг стандартын дагуу хийж халдварлалтгүй болохыг тогтоож ажилласан. Мөн аймгийн төв Сүхбаатар сумын худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй МАА-н гаралтай мах, махан бүтээгдэхүүний 21990 кг махны 229 дээж, 570 л сүүний 19 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж ариун цэврийн гэрчилгээ олгосон.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:**

2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс “Улсын бүртгэлийн тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүртгүүлж, Э, А бүртгэлийн дугаар авч эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Эд хөрөнгийн бүртгэлийн газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн дугаар авах ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Тайлант сард газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 32 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Тэлсэн талбайн хэмжээг нэгж талбар тус бүрээр гаргаж, шинээр атар хагалсан болон газар дээр нь очих шаардлагатай 47 талбайд хээрийн хэмжилт хийсэн. 2018 оны 11 дүгээр сарын 08-ны байдлаар 8 сумын 136367,25 га тариалангийн талбай нэг бүрийн кадастрын зураглалыг “Спот, Ландсат, Сэнтинел” зэрэг хиймэл дагуулын мэдээнд суурилсан зургийг ашиглан шинэчлэн тогтоож, илэрсэн 7901 га талбайн зөрчлийг ангилвал

ихэвчлэн тэлсэн, зурганд буруу орсон, захирамж гарсан боловч мэдээллийн санд бүртгэгдээгүй асуудлыг хянан баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах Шаамар сумын Дулаанхан тосгоны төрийн албан хаагчийн 8-н айлын орон сууцны зураг төсөл, Жавхлант сумаас Хушаат сум хүртэлх өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох газрын шилэн кабел суурилуулах ажлын зураг, Шаамар сумын төвийн төрийн байгууллагуудыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох зураг төсөл, Жавхлант сумын Хар морьтын хөтөлд “Мобиком” ХХК-ий үүрэн холбооны станцын гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, Шаамар сумын Дулаанхаан тосгоны 320 хүүхдийн сургуулийн их засвар, Хушаат сумын Эмнэлгийн барилгын сантехникийн засварын ажлын зураг төслийг тус тус хянаж, Алтанбулаг сумын “Алтанбулаг чөлөөт бүс”-д баригдсан “Цахим ертөнц” ХХК –ий худалдааны төвийн барилга угсралтын ажил, Баруунбүрэн суманд баригдсан сургуулийн дотуур байрны өргөтгөлийн барилга угсралтын ажил, Баянгол суманд “Цас эрчис” ХХК–ий гүйцэтгэсэн Цамхагт гэрлийн ажил, Баянгол болон Мандал сумдад “Хөрс ХХК”–ий ШТС –ын барилгууд, Мандал суманд “Мобиком ХХК” –ий захиалгаар хийгдсэн 15 метр өндөртэй холбооны цамхаг, Жавхлант суманд “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК –ий гүйцэтгэсэн 250 метр сайжруулсан зам, цамхагт гэрэлтүүлгийн ажил болон төв замын нөхөөс хийх ажлуудад Улсын комисс ажиллалаа.

### **Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд**

2018 оны 11-р дүгээр сарын 02, 13, 17, 18-ны өдрүүдэд ихэнх сумдын нутгаар 0,0-5,0 мм цас орлоо. Бусад хугацаанд цас ороогүй. Ихэнх хугацаанд салхи баруун болон баруунаас 4-9 м/сек байв. 13, 17-ны өдрүүдэд нийт нутгаарсалхи баруун хойноос 8-13 м/сек хүрч шороон болон цасан шуурга шуурсан.

Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Хушаат зэрэг сумдын нутгаас бусад сумдыннутгаар 0-9 см цасны зузаантай бол хамгийн их нь Бугантад 9 см цасан бүрхүүлийн зузаантайбайна. Сарын эхний арав хоногийн эхэн болон 2-р арав хоногийн дунд үе хүртэл шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байсан бол 2-р арав хоногийн дунд үеээс хойшхүйтэрч шөнөдөө 15-20 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн байлаа.

Сэлэнгэ аймгийн гол мөрний усны түвшин Сэлэнгэ мөрний усны түвшин Зүүнбүрэн сум орчмоор 224 см олон жилийн дунджаас 4 см-ээр их, Сүхбаатар сум орчмоор 251 см олон жилийн дунджаас 11 см-ээр их, Ерөө голын усны түвшин Ерөө орчмоор 345 см олон жилийн дунджаас 8 см-ээр их, Дулаанхан сум орчмоор 283 см олон жилийн дунджаас 76 см-ээр их, Орхон гол Сүхбаатар сум орчмоор 1 см олон жилийн дунджаас 52 см-ээр их, Орхонсум орчмоор 148 см олон жилийн дунджаас 63 см-ээр их, Хараа голын усны түвшин Баянгол сум орчмоор 171 см олон жилийн дунджаас 17 см-ээр их, Хүдэр голын усны түвшин Хүдэр сум орчмоор 279 см олон жилийн дунджаас 69см-ээр их байгаа бол Зэлтэр голын усны түвшин Түшиг сум орчмоор 232 см олон жилийн дунджаас 18 см-ээр бага байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын 11-р сарын 2-р арав хоногийн ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.008 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.0 19мг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн дундаж агууламж 0.030 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.055 мг/м<sup>3</sup>, нийт тоосны дундаж агууламж 0.102мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.315 мг/м<sup>3</sup> РМ10 тоосонцор 11-р сарын 19-ний оройн 20 цагт хүртэл агууламжаас 1.02 дахин давсан бөгөөдагаар болон хөрсөндээрхи цацрагийн түвшин фон түвшнээс даваагүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2018 оны зардлаар нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр 10 000 000 төгрөг төсөвлөсөн. Ажлын гүйцэтгэгчээр Ерөө бүсийн сум дундын Ойн анги, Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги, Хараа бүсийн сум дундын ойн анги, Орхон бүсийн сум дундын Ойн анги, Хүдэр сумын Ойн ангиудыг сонгон авч

“Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж санхүүжилтийг нэг Ойн ангид 2 000 000 төгрөг буюу нийт 10 000 000 төгрөгийг 100 хувь олгосон.

Сумын болон сум дундын ойн ангиуд Алтанбулаг, Баруунбүрэн, Цагааннуур, Түшиг, Ерөө, Хушаат, Сант, Хүдэр, Мандал, Жавхлант зэрэг сумдын нэр бүхий 19 агнуурын бүс нутгуудад ойн нөхөрлөлийн ахлагч, гишүүд, сумдын БОХУБ, байгаль хамгаалагч нартай хамтран биотехникийн зарим арга хэмжээг чанартай сайн хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “2018 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай” 153 тоот тогтоолоор үйлдвэрлэлийн огтлолтоор 100 м3 мод тутамд 2 га, арчилгаа болон цэвэрлэгээний огтлолтоор 100 м3 мод тутамд 1.5 га талбайд ойжуулалтын ажил, мөн уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор ойгоос мод бэлтгэсэн иргэнээр 1 модны оронд 10 мод тарьж ургуулах ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нийт 86115 м3 хэрэглээний мод бэлтгэж 1452,6 га талбайд ойжуулалтын ажил хийх төлөвлөгөөтэй байснаас жилийн эцсийн байдлаар мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр 867,3 гаруй га талбайд ойжуулалтын ажлыг гүйцэтгэсэн.

БОАЖГазрын даргын 2018 оны А/30 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ойн зурвас байгуулах ажил, мод үржүүлгийн газар өргөтгөх ажил, ховор ургамал тарималжуулах ажлуудын биелэлт гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж актаар хүлээн авч ажиллаж, тайлан, актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтүүдийг олгосон.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар аймгийн хэмжээнд ургаж буй нэн ховор, ховор, элбэг, ашигт ургамал болон эмийн ургамлын судалгаа, тархац, нөөц, зураглал, тооллого зэргийн иж бүрэн судалгаа, материал, мэдээллийн сантай болох зорилгоор “Байгалийн ургамлын аймгийн тооллого, зураглалыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажил”-ыг 2017 онд тусгаж оруулсан ба ажлын гүйцэтгэгчээр “Экотайкүүн” ХХК шалгарч 2018 онд гүйцэтгэж дуусгасан ба тооллого, судалгаагаар аймгийн хэмжээнд уулын-ойн бүслүүрийн ургамалжилтын 63 овогт хамаарах 258 төрлийн 611 зүйл, уулын хээрийн бүслүүр, хээрийн бүс, нугын хээр ба татмын нугад 78 овгийн 304 төрөлд хамаарах 605 зүйл тус тус бүртгэгдлээ.

2018 оны 11-р сарын 27-28-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал суманд “Зочлох үйлчилгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамж” сэдэвт үйлчилгээний салбарын ажлын байрны стандарт мөрдөлтийг хангах, үйлчилгээний технологийн ур чадварын дадал эзэмших аргачлалд сургах, мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Мандал суманд үйл ажиллагаа эрхлэн явуулдаг зочид буудал, ресторан, зоогийн газрын захирал, менежер, үйлчилгээний ажилчид болох 30 хүн хамрагдсан.

“Монгол улсын тогтвортой аялал жуулчлал, хүртээмжтэй эдийн засаг” төслийн хүрээнд 2018 оны 11 дүгээр сард төслийн аймгуудад зочид, аялагч, жуулчид хүлээн авч үйлчилгээ үзүүлэгч гол байгууллага, аж ахуйн нэгжүүд болох зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, гэр бааз буудлууд, түүнчлэн ресторан, зоогийн газар, гуанзны менежер, удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Улаанбаатар хотод BIZ-Бизнес Инноваци Хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтанд Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Мандал сумын зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, ресторан, зоогийн газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20 аж ахуйн нэгж байгууллагын захирал, менежерүүд хамрагдаж, зочлох үйлчилгээний онцлог, бизнесийн борлуулалт-маркетинг, харилцааны ур чадварын талаар онолын мэдлэг бататган, харилцааны ур чадварын дадлага, туршлагаа хуримтлууллаа.

2018 онд аймгийн хэмжээнд нийт 134.04 га талбай уулын ажлын төлөвлөгөө болон бичил уурхайн зориулалтаар олборлолтод өртсөн ба 117.5 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээсэн талбайг сум тус бүрээр үзүүлбэл: Ерөө сум 63 га, Баянгол сум 37.3 га, Орхонтуул сум 4 га, Мандал сум 9.2 га, Сайхан сум 4 га нийт 117.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Үүний 26.7 га талбай нь биологийн, 90.8 га талбай нь техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 05 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2018 оны А/397 тоот “Ажлын хэсэг томилох тухай” захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 онд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулсан Баянгол сумын “Бороогоулд” ХХК, “Тод-Ундрага” ХХК, “Сонор трейд” ХХК, Ерөө сумын “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Ди Зэт энд Ай” ХХК, “Толгойтын гол” ХХК, “Ганбат тулга” ХХК, Сайхан сумын “Цемент Шохой” ХК, Түшиг сумын “Шар нарст” ХХК нийт 9 аж ахуйн нэгжийн 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг шалгаж дүгнэлт гарган холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн БОНХАЖСайдын 2015 оны А/416 тоот тушаалын дагуу аймаг, сумын хамтарсан бүрэлдэхүүнтэй комисс “Ди Зэт энд Ай” ХХК 2.1 га техникийн болон биологийн, “Ганбат тулга” ХХК 14 га техникийн, 4.3 га биологийн, “Бугант нандин” ХХК 5.4 га техникийн болон биологийн, “Толгойтын гол” ХХК 1.1 га техникийн, “Болд төмөр Ерөө гол” ХХК 10 га биологийн, “Тод-Ундрага” ХХК 11.8 га техникийн, 3 га биологийн, “Бороогоулд” ХХК 0.5 га биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хүлээн авч ажиллалаа.

### **Найм.Сум орон нутгийн талаар**

#### **Алтанбулаг сум:**

2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр 3 дугаар багийн иргэдэд, 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр сумынхаа нийт төрийн албан хаагчдад, 21-ний өдөр сумынхаа ахмадуудад Засаг даргын ажлын албанаас Алтанбулаг суманд 2018 онд хийгдсэн ажлын тайланг танилцуулж, Засаг дарга цаг үеийн ажлын талаар танилцуулга хийлээ.

Хүүхдийн сурах үйлийг дэмжихүйц сонирхолтой хөгжүүлэх үйл ажиллагааг багш нар хамтран баг болон явуулсан. Энэ сард хөдөлгөөн эрүүл мэнд, хөгжмийн чиглэлээр үзүүлэх хөгжүүлэх үйл ажиллагааг явуулж байна. Сумын Цагдаагийн тасгаас “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сургалтын гарын авлага” ном өгсөн.

2018-2019 оны хичээлийн жилд Оюун ухаан дэд хөтөлбөрийг 3 багш, 4 туслах багш нар хариуцан ажиллаж бүлэг бүр ангидаа өглөөний хүлээн авалт, орой таралтын цагаар хүүхдүүддээ могой шоо, долоодой, спорт өрөлт зэргээр хүүхдийн сэтгэн бодох чадвар, анхаарал, ой тогтоолт, зохион бодохуй зэргийг нь хөгжүүлэн ажиллаж байна. Хүн болох багаасаа хөтөлбөрийн Оюун ухааныг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд бид 11-р сард ахлах, бэлтгэл хүүхдүүдийн дунд асуулт хариултын “АХА” тэмцээн, Могой шоогоор хэн хурдан дүрс бүтээх вэ?, дунд бага бүлгийн хүүхдүүдийн дунд долоодой дүрс эвлүүлэх, дүрс бүтээх уралдааныг амжилттай зохион байгууллаа. Мөн хөтөлбөрийн Авьяас дэд хөтөлбөрийн хүрээнд дунд, бага бүлгүүдийн дунд “Бяцхан бүжигчин” тэмцээнийг тус, тус зохион байгууллаа.

ЕБС-ийн сурагчдын үдийн цай хөтөлбөрийг дэмжин 1-р ангийн эцэг эхийн 780000 төгрөгийн хандиваар гал тогооны гурван дамжлагат угаалтуур, ус халаагчийн хамт шинэчлэн байрлууллаа.

Соёлын төвд 11 дүгээр сарын байдлаар урлаг соёлын нийт 16 арга хэмжээнд давхардсан тоогоор 822 хүн хамрагдсан байна. Сумын СМТ-өөс Найрамдал, Дамбо цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “Үлгэрийн баатруудын дүрд” жүжигчилсэн тоглолтонд ахлах бүлэг МАУ “Долоон өндөгтэй доголлон шаазгай” үлгэрээр, бэлтгэл бүлэг ОАУ “Улаан малгайт” үлгэрээр амжилттай бэлтгэн оролцож ахлах бүлэг 1-р байранд шалгарлаа.

Сар бүрийн 20-ны өдрийн "Дуула хөдөр дуун цэнгүүн" арга хэмжээг энэ удаад сумын Засаг даргын Тамгын газраас "Ахмадаа дээдэлсэн Алтанбулагчууд" нэртэйгээр хамтран зохион байгуулж, ахмадуудын дунд "Караоке дууны тэмцээн зохион явууллаа. Мөн 7 хоног бүрийн баасан, бямба гаригт нийтийн цэнгээнт бүжгийг зохион явуулж байна. Энэхүү бүжгийн үеэр шинэчлэгдсэн 18 бүжгийг зааж сурган ажиллаж байна.

Улаанбаатар хотын Дентамон эмнэлгийн шүдний эмч нартай хамтран сумын эрүүл мэндийн төвөөс 9-р ангийн 22 хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулж картжуулж “Шүдийг яаж арчлах” талаар сургалтыг хийж үнэгүй шүдний сойзыг сургалтанд хамрагдсан хүүхдүүдэд тараасан мөн гарын авлагыг өгсөн. Шүдний цооролттой 1 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. “Элэг бүтэн-2” хөтөлбөрийн дагуу 15-39 насны 1022 хүнд шинжилгээ хийснээс Элэгний В,С вирус илэрсэн 77 хүнээс аймгийн “Гэрэл” лаборатори ЭМТ дээр ирж вирус тоолох шинжилгээнд 42 хүнийг хамрууллаа.

### **Шаамар сүм:**

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 11 дүгээр сарын байдлаар малчин мал бүхий иргэд 5000 тн өвс хадаж хадлан тэжээлийн бэлтгэл 100% дууссан. Сумын нөөцөд 8 тн өвс бэлтгэж, хужир 2 тн ирж иргэдэд худалдан борлуулж дууссан. Сүрэл 10 тн, ногоон тэжээл 7 тн, хүчит тэжээл 10 тн-ыг бэлтгэсэн байна. Үр тарианы хураалт улаанбуудай 1793 га-аас 968 тн ургац, гурвалжин буудай 465 гас-аас 465 тн, төмс 81.5 га-аас 125 тн, хүнсний ногоо 229 га-аас 3224 тн, жимс жимсгэнэ 13 га-аас 13,5 тн хураасан байна.

Байгууллагын ажилтан албан хаагчдад 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хуулийн шинээр тусгагдсан зүйл заалт, төрийн албан тушаалтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, хууль зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын талаар танилцуулж нийт 30 ажилтан албан хаагч хамрагдсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх ажилд төрийн албан хаагчдыг бүрэн хамруулж 15 төрийн захиргааны албан хаагчийг Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн албаны тухай хууль болон компьютерийн шалгалтанд хамруулж хангалттай үнэлэгдсэн.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын дагуу хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Эрүүл оюутан-Хөгжлийн түүчээ” аяныг удирдамжийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан сумын Эрүүл мэндийн төв, Соёлын төвтэй хамтран зохион байгуулсан. Аяны хүрээнд МСҮТ-ийн оюутан сурагчдад халдварт ба халдварт бус өвчний талаар мэдлэг олгох, эрүүл зөв дадал хэвшлийг өдөр тутмын амьдралд төлөвшүүлэх зорилгоор “Халдварт ба халдварт бус өвчин” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Нийт 40 оюутан хамрагдсан.

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хадлан бэлтгэл, өвс тэжээлийн мэдээг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.

Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын баярыг тохиолдуулан сумын нийт ногоочин, зөгийчин, малчин, тариаланч иргэдийн дунд “Алтан намар” арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээний үеэр баярын хурал, урлагийн тоглолт, үдшийн цэнгүүн, гар бөмбөг, теннисны тэмцээн зохион байгуулж нийт 250 гаруй иргэд оролцлоо.

Монголын Их дээд сургуульд 2008-2017 онд төрийн сангийн зээлээр суралцаж төгсөөд төрийн байгууллагад ажиллаж байгаа сургалтын төлбөрөө төлөөгүй, боловсролын баримт бичиг эх хувиараа байхгүй албан хаагчдын судалгаа болон хөгжлийн бэрхшээлтэй 0-18 настай хүүхдүүдийн судагааг нэгтгэн боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Хүүхдийнхээ нас болон сэтгэлзүйн онцлогт тохируулан харьцаж сурах, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудыг танилцуулах зорилгоор эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан хаагчдын дунд “Хүүхэд-Монголын баялаг” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын “Мөрөөдлийн гүүр” Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж ажилласан. Нийт 80 гаруй иргэд хамрагдсан.

"Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 12 өрхийн 133 гишүүнд 2018 оны 11 дугаар сарын талон болох 121 ширхэг үнэт цаас бүхий

968000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа. Мөн " Хүүхдийн мөнгө" авах хүсэлтээ ирүүлсэн шинэ төрсөн 1 хүүхдийн материалыг хүлээн авч ХХҮГазарт хүргүүлсэн. Ахмадын байгууллага болон "Мөнгөтийн Таг" Төрийн бус байгууллагатай хамтран 80 ахмад настанд өдрийн үйлчилгээг зохион байгууллаа.

### **Хүдэр сүм:**

Монгол Улсын Засгийн газраас төрийн жинхэнэ албан хаагчдын мэргэшлийн түвшин тогтоох судалгаанд хамрагдах ажлыг зохион байгуулан төр төсвийн албан хаагчдын дунд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Үндсэн хуулиудаар сургалтыг зохион байгуулж мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэн судалгаанд амжилттай хамрагдсан. Энэ ажлын бэлтгэл хангах үүднээс төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж, ажлын хариуцлага, цаг ашиглалтыг сайжруулах талаар сумын Засаг даргын 2018 оны А/135 тоот захирамжийг гарган сумын нийт ТАХ-д танилцуулан мөрдөн ажиллаж байна. Мөн байгууллагын дотоод журамд ЗДТГ-ын даргын 2018 оны 9-р сарын 03-ны өдрийн А/09 тоот тушаалаар өөрчлөлт оруулж, ТАХ-чид, төр төсвийн байгууллагын үйл ажиллагааны талаар санал асуулга авлаа.

Сумын Соёлын төв нь бүжиг, хөгжмийн дугуйланг хичээллүүлж байгаа бөгөөд, хуваарийн дагуу ажлын 7 хоногийн 2 өдөрт хичээллэж байна. Түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг маршрутын дагуу эргэх ажлыг гүйцэтгэж, 41 булш, соронзон хад, 3 тогоо, тахилгат овоо 2, хөшөө дурсгал 5, нийт 56 нэр төрлийн зүйлийг хамрууллаа.

Өрхийн амьжиргааны түшин тогтоох судалгаанд 5 иргэнийг хамруулан, АДЗ-ийн хурлаар дэмжсэн иргэдийн материалыг аймагт хугацаанд нь хүргүүлсэн.

Сумын Засаг даргын А/169 захирамжийн дагуу Малын халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 2018 оны 10-р сарын 30-наас 11-р сарын 16-ны хооронд 10,000 хонинд вакцины ажлыг хийж, 104 малчин өрхөөр өвөлжилтийн бэлтгэл хангасан талаар судалгаа, мэдээлэл авахад, 80 гаруй хувь нь өвөлжилтийн ажлаа сайн хангасан байна.

2018 онд онд улаан буудай 6209 га-д, Арвай 126 га-д, овьёос 208 га-д, рапс 125 га-д, төмс 70 га-д, хүнсний ногоо 48 га-д тариалалт хийж, нийт үр тариа -7712 тн төмс- 700 тн, хүнсний ногоо- 396 тн, арвай -114 тн, овьёос- 250 тн, рапс- 200 тн тус тус хураан авч 38 ногоочин, 7 аж ахуйн нэгж, 1 иргэн үр тариа тариалсны дагуу статистикийн цахимд нийт 102 малчин өрхийн судалгааг шивж орууллаа. Сумын үр тарианы норм төлөвлөгөө биелсэн. Тариалангийн талбайн түүх хөтлөлтийн дэвтэр "Хурниад Хүдэр", "Ургац Хүдэр", "Монгол Сафори", "Төхмийн нуга", "Арвин бэлчир" ХХК-ууд хөтөлж, агротехнологийн картыг 5 жилээр хөтөлж хэвшсэн. Сумын ногоочдын холбоог байгуулан Хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоонд гишүүнээр элссэн бөгөөд нийт иргэд 48 га газарт ногоо тариалж 103 цн ногоо хураан авлаа.

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 153 дугаар тогтоол, Сумын ИТХ-ын 77, 78 дугаар тогоолоор 21,960 шоо метр мод хуваарилагдаж дээрх модыг 21 аж ахуй нэгж, 8 нөхөрлөлд хуваарилсан. 2018 оны 11-р сарын байдлаар хэрэглээний 13,530 м3 мод хуваарилагдсанаас 9,973 м3, түлээний мод 8310 м3 хуваарилагдсанаас 4378 м3 мод бэлтгэгдэж мод бэлтгэлийн гүйцэтгэл 65.4 хувьтай, ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөг 149,889,825 төгрөгөөр төлөвлөж 127,802,715 төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлж 85,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын ИТХурлын 2018 оны 03 дугаар 22-ны өдрийн 79 тоот журмын дагуу Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 11-р сарын 20-22-ны өдрийн хооронд дүгнэж дүгнэлтийг сумын ИТХ-ын өргөтгөсөн хурлаар хэлэцүүлэхээр бэлтгэлийг ханган ажиллаж байна. Мөн хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, эргүүл шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг

хангуулах зорилгоор удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 3 удаа хийж нийт 65 иргэнд зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Ирээдүй хойч үедээ эрүүл байгалиа үлдээцгээе” аяны хүрээнд 10-р сарын 30-ны өдөр Хүдэр сумын ЕБСургуулийн Эко Зөвлөлийн сурагчид болон иргэдэд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль тэдгээртэй холбогдох дүрэм журмын талаар мөн Хөрсний бохирдол, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар 1 удаа сургалт зохион байгуулж, брошур, гарын авлага хэвлэн тарааж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчиллаа.

### **Ерөө сүм:**

2018 онд 15 аж ахуй нэгж, 14 иргэн 15987,44 га талбайд үр тариа, тосны ургамал тариалсанаас 13908,44 га-д улаанбуудай, 22 га-д арвай, 67 га-д овьёос, 1732 га-д рапс, 258 га талбайд гурвалжин буудай тус тус тариалсан. 11 дүгээр сарын 27-ны байдлаар үр тариа, тосны ургамал нийт 15242 га-аас талбайгаас 18595.6 тн ургац хураан авч сумын хэмжээнд тариа хураалт 96 %-тай дууссан. Төмс 68 га талбай хураан авсанаас 750 тн буюу 110 цн, хүнсний ногоо 70,6 га талбай хураан авсанаас 762,2 тн, нэгжийн ургац 107 цн байна.

“Ургацын баяр-2018” арга хэмжээ зохион байгуулагдаж сумын хэмжээнд газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан зохион байгууллаа. Баярын үеэр 2018 оны шилдэгийн шилдэгүүдээ тодрууллаа. 2018 онд нэгж талбайгаас хамгийн их хэмжээний ургац хураан авсан аж ахуйн нэгжээр “Доолт” ХХК, нэгж талбайгаас хамгийн өндөр ургац авсан аж ахуйн нэгжээр “Ачит Буурагчин” ХХК, нэгж талбайгаас хамгийн их хэмжээний ургац хураан авсан ногоочноор иргэн Н.Баясах, хамгийн өндөр ургац хураан авсан ногоочноор иргэн Б.Сэргэлэн, ХАА-н салбарын шилдэг механикжуулагчаар иргэн Х.Азбаяр, салбарын шилдэг үйлчилгээний ажилтанаар Р.Анхтуяа, нийгмийн хариуцлагаар тэргүүлэгч аж ахуй нэгжээр “Доолт” ХХК, сумын аварга хадланчаар иргэн С.Лхагвасүрэн, аварга тариаланч хамт олооор “Шинэ тариа” ХХК тус тус шалгарлаа.

“Бид Ерөөгийн баялаг бүтээгчид” үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Нийт 19 нэр төрлийн дарж даршилсан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, төмс, хүнсний ногоо мод модон эдлэл /Өргөст хэмх, дунайскы салат, луувангийн салат, лечо, гүзээлзгэний чанамал, дарсан лууван помидор, алаг салат, хүрэн манжингийн салат, кимчи, сүү, тараг, ааруул, аарц, хайлмаг, гишүүнэ, эзгий, шар сүүний ундаа, боролзгоно, төмс, лууван, шар хүрэн манжин, сонгино, байцаа, хулуу, сармис, халиар, сандар шалны мод зэрэг бүтээгдэхүүнүүд зарж борлуулан 864,000 төгрөгийн борлуулалт хийлээ.

“Иргэний андгай өргөх ёслол” арга хэмжээг 12 жилийн сургуультай хамтран 11-р сарын 23-ны өдөр зохион байгуулж, сурагчдад “Иргэний андгай өргөхийн учир” зураглал үзүүлж, иргэний үнэмлэх батламжийг гардуулах, андгай өргүүлж, шилдэг сурагчдыг өргөмжлөх арга хэмжээ авч, урлагийн тоглолт, “АХА” асуулт хариултын тэмцээн арга хэмжээнүүдийг тус тус явууллаа.

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музей, Ерөө сумын Соёлын төв, 12 жилийн сургуулийн 9а, 9б ангиудтай хамтран “Сэлэнгэ сайхан нутаг” тойрон аялалд 9 ангиудын 51 сурагч анги удирдсан багш Ш.Болортуяа, Э.Уянга, Нэгдсэн музейн ЭШАжилтан Д.Наранчимэг, сумын ОНСТ-ын ажилтан Б.Алтанцэцэг нарын нийт 55 хүний бүрэлдэхүүнтэйгээр Алтанбулаг хөшөө-Буур хээрийн хөшөө-Сэлэмт хөшөө-Төгсгөө булаг-Дөрвөлжин сүмийн туурь-Наймаачин хотын туурь-Салдат толгой-Алтанбулаг хилийн боомт-МУ-ны 0312 хил хамгаалах анги-Ардын түр засгийн газрын байшин -Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей гэсэн маршрутаар аялаад ирлээ. Уг аялалд Соёлын төвөөс 47000 төгрөг зарцуулсан байна.

“Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай”, “Хог хаягдлын тухай”, “Хууль бус мод бэлтгэл”, Мөнгөн усны бохирдолын талаар талаархи гарын авлага, боршурыг бэлтгэн иргэд, малчдад өглөө.

“БТЕГ” ХХК-ий байгаль орчны менежмент төлөвлөгөөний тайланг хэлэлцэх ажилд аймаг, сумын холбогдох мэргэжилтнүүд, Хараа Ерөө голын сав газрын захиргааны ажилтан оролцож, тайлан 89,6 хувьтай дүгнэгдлээ.

2017 оны 12 дугаар сарын 07-ний өдөр батлагдан гарсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг талаар мэдээллийг 2018 оны 11 дугаар сарын 13-ний өдөр 23 иргэн болон төр төсвийн байгууллагын 77 албан хаагчдад хүргэж хуулийн талаарх мэдээлэл бүхий 100 ширхэг гарын авлага материалыг төрийн албан хаагч иргэдэд тараан өгч ажиллалаа. Уг сургалтаар төрийн албаны тухай хуулийн шинэ үзэл баримтлал, бүтэц, дагаж мөрдөх хугацаа, нийтлэг үндэслэл, шинэ зохицуулалтууд, чадахуйн зарчим, төрийн албаны шалгалт, нийтлэг шаардлага, төрийн албан хаагчийн төлөвлөгөө, шинээр олгох тусламж нэмэгдэл хөлс, ТАЗ маргаан хянан шийдвэрлэх, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих, зарчим, хуулийн ач холбогдолын талаар мэдээлэл өглөө.

Элэгний гепатитын эрт илрүүлгийн шинжилгээнд нийт 764 хүн хамруулсан бөгөөд элэгний В,С вирустэй, сул эерэг, эргэлзээтэй 82 хүн буюу 10 хувийг эзэлж байна. Элэгний В,С вирусн шинжилгээнд хамрагдахын ач холбогдол, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ 2016-2018 оныг тасралтгүй бөглүүлж, үзлэг шинжилгээнд орох 15-39 насны 12 хүний 362400 төгрөгийн сайн дурын даатгал хийлгэсэн. Ингэснээр иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагсдын хувь 100 болсон.

Монголын их дээд сургуульд 2008-2017 онд төрийн сангийн зээлээр суралцаж төгсөөд төр, хувийн хэвшилд ажиллаж байгаа сургалтын төлбөрөө төлөөгүй, боловсролын баримт бичиг эх хувиараа байхгүй албан хаагчид болон одоогоор ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний судалгааг гаргасан. Уг судалгаагаар Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг зэрэг төр төсвийн байгууллагад ажилладаг албан хаагчдаас төрийн сангаар суралцаж төгссөн хүн байхгүй, ЗДТГазрын ажилтан 1 хүн байсан. 2018.11.19-ны өдөр Ерөө сумын хөгжлийн бэрхшээлтэй 1-18 насны хүүхдийн судалгааг гаргасан. Уг судалгаагаар сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүүхэд байдаг тэдгээрийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, сургуульд суралцдаг эсэх, мөн халамж авдаг эсэх талаар ерөнхий судалгааг гаргасан. Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 19 хүүхэд, үүнээс халамж авдаг 7 хүүхэд, сургуульд суралцдаг 18 хүүхэд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр тулах хөдлөх эрхтэний, сонсголын, харааны 2018.11.14-ны өдөр “Эрүүл оюутан-хөгжлийн түүчээ” аяны хүрээнд Ерөө сумын “Эрүүл мэндийн төв”, “Ерөнхий боловсролын сургууль”-тай хамтран сурагчдад сургалт семинар зохион байгууллаа. Уг сургалтанд ерөнхий боловсролын сургуулийн 7-11 ангийн нийт 100 гаруй хүүхэд хамрагдсан.

2018 оны 11-р сарын 10-нд Ахмадын “Дуулах өдөр, дуун цэнгүүн” –ийг зохион байгуулж, урилгаар Дархан-Уул аймгийн XVI хорооны ахмадууд хүрэлцэн ирж ая дуугаа өргөн урлагийн тоглолтоор бэлэг барилаа. Мөн сарын 17-нд Ерөө Соёлын төв, 12 жилийн сургууль хамтран “Ая дуу-2018” дууны уралдааныг зохион явууллаа.

### **Зүүнбүрэн сум:**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2 удаа хуралдан сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2019 оны төлөвлөгөөний төсөл, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2019 оны төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталлаа.

“Ургацын баяр-2018” арга хэмжээг зохион байгуулж шилдгүүдийг 5 чиглэлээр тодруулан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”, аймаг, сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шилдгүүдийг шагнаж урамшууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 153 тоот тогтоолын дагуу Түшиг сумаас 151 өрхөд 633м<sup>3</sup> түлшний мод олгоод байна.

“Ургацын баяр- 2018” арга хэмжээний хүрээнд “Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл” эрхлэгч иргэдийн дунд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 41 иргэн 18 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцлоо. Аймаг, сумын Засаг даргын үйл



ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл малтай өрх” шалгаруулах судалгаанд 350 малчин өрхийг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд зохион байгуулах спортын тэмцээнд амжилттай оролцон “Шилдэг зохион байгуулалттай сум”-аар шалгарлаа.

Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан “Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээг зохион байгуулж, суралцагчийн өөрийн удирдлагын зөвлөл, ХОУЗ-ийн дарга, гишүүд оролцон санал бодлоо солилцлоо. Хүүхдүүдээс 10 чиглэлийн санал гарсан ба саналуудыг Хүүхдийн зөвлөлийн тэргүүнд дэвшүүллээ.

2018 онд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэдийн дунд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд 5 иргэн оролцож 200 гаруй мянган төгрөгийн борлуулалт хийлээ. Ажилгүйдлийн LMIS програмд ажилгүйдлийн бүртгэлд 26 иргэн ажил идэвхитэй хайгчаар бүртгэлтэй байна. Шинэ ажлын байранд 8 иргэнийг бүртгэж нийт шинэ ажлын байр 31-ийг бий болголоо.

Амбулаторын үзлэгт 286, өвчний учир- 162, урьдчилан сэргийлэх үзлэгээр 80, дисдансерийн хяналтаар 24, гэрийн идэвхтэй эргэлтээр 16, дуудлагаар 4 иргэнийг үзэж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүллээ.

2018 оны 11 дүгээр сарын хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 3080 хүүхэд өдөр хамруулахаас 2008 хүүхэд өдөр хамруулж 65 хувьтай, 24 бүлэгийн хүүхэд хоногийн төлөвлөгөөнд 380 хүүхэд хамруулахаас 236 хүүхэд хамруулж хамран сургалт 62 хувьтай байна. Багш нарын дунд заах арга, ур чадварын уралдааныг зохион байгуулж Бага боловсролын багш нараас 1 дүгээр байрт Г.Ариунцэцэг, 2 дугаар байрт Б.Солонго, 3-дугаар байрт Б.Сарантуяа багш, дунд ахлах ангийн багш нараас 1 дүгээр байрт Н.Баярцэцэг, 2 дугаар байрт Д.Мөнхгэрэл, 3 дугаар байрт Б.Ганцог багш нар тус тус шалгарлаа. Энэ сарын 16-17-ны өдрүүдэд “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Баруун бүсийн 9 сумын багш нарын арга зүйг дээшлүүлэх сургалтыг амжилттай зохион байгуулж сургалтанд 55 багш хамрагдлаа.

“Харилцааг эерэг болгоё” сарын аяныг 2018 оны 11-р сарын 01-нээс 12-р сарын 01 зарлагдсан ба уг аяны хүрээнд “Сэтгэлийн илгээмж” 7 хоногоор багш ажилтанд сурагчид захидал бичих үйл ажиллагаа явагдаж захидлыг эзэнд нь хүргэж байна. Мэргэжлийн багш нар нэгж хичээл бүрээр үнэлгээний даалгавар боловсруулан тухай бүрд нь сурагчдаас авч анализ хийн сургалтын менежерт шилжүүлж байна.- “Математик цаг” сонины стандарт уралдаанд 2-5-р ангийн 102, 6-11-р ангийн 45 сурагч, нийт 147 сурагч хамрагдсан. Мөн “Кенгуру-2018” олимпиадад дунд ахлах ангийн 25 сурагч, бага ангийн 60 сурагч, нийт 85 сурагч хамрагдсанаас 10а ангийн сурагч Г.Номин, 4б ангийн сурагч М.Төгсжаргал, 3а ангийн сурагч У.Энх-Оргил, С.Тэргэл нар 3 дугаар зэрэг, 5а ангийн сурагч Ц.Болор, Х.Бат-Ялалт, 4а ангийн сурагч Э.Ганбаяр нар 2 дугаар зэрэг авлаа.

“Хүүхэд–Монголын баялаг” үндэсний зорилтот, сургамжит цуврал лекцийг хүүхдийн сэтгэл зүйн мэргэшсэн зөвлөх лектор Ш.Алтанцэцэг бага ангийн сурагчдын эцэг эхийн дунд зохион байгуулж 23 эцэг эхийг хамрууллаа. Сургуулийн эмч “Эрүүл мэнд” бүлгийн сурагчидтай хамтран 1-11 дүгээр ангийн сурагчдад “Гар угаах” “Шүд угаах” сургалтыг зохион байгууллаа.

### **Мандал сум:**

Мандал сум БНСУ-ын Ы-сон сумтай хамтын ажиллагаа тогтоосны 10 жилийн ойн баярын хурал, концерт “Мөнгөн Хараа”дуу бүжгийн чуулгад зохион байгуулагдлаа. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Ы-сон сумаас Мандал сумын Зүүнхараа политехникийн коллежид газар тариалангийн иж бүрэн парк байгуулах зэрэг 470 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Залуучуудын хөгжлийн тухай хууль 2018 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан "Залуучуудаа сонсьё" уулзалтыг "Иргэний танхим"-д зохион байгуулагдаж, Мандал сумын Засаг дарга бөгөөд Залуучуудын хөгжлийн салбарз өвлөлийн тэргүүн Н.Лхагвадорж, дэд тэргүүн Засаг даргын орлогч Л.Мөнхбат нарын удирдлагууд орон нутгийн албан байгууллагын залуусын төлөөллийг хүлээн авч,

2016-2018 онд суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээлэл, 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөө, төсөвт суугдсан ажил, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх, нийгэмд залуусын оролцоог нэмэгдүүлэх талаар мэдээлэл хийж, харилцан ярилцаж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Сумын ахмад настнуудад зориулан Дархан-Уул аймгийн Мөнгөтийн таг ТББ-тай хамтран "Ахмад настны өдрийн үйлчилгээ"-г 2018.11.21-нээс 2018.11-23-ны хооронд зохион байгуулсан. Тус өдрийн үйлчилгээнд 260 ахмад настан хамрагдан 10 төрлийн үйлчилгээг үзүүллээ.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдах хүсэлтэй 578 иргэний өргөдөл ирснээс 480 өрхөөр зочилон судалгааг авч 313 өрх шийдвэрлэгдэн, 167 өрх хяналт хийгдэн уламжилсан төлөвт байна. Судалгааны явц 83 хувьтай явагдаж байна.

WiFi, интернэт үйлчилгээг уншигчдад хүргэж, шинэ мэдээллээр хангаж сонсдог номыг уншигчдад уншууллаа. Монгол улсын төрийн түүх, бичгийн соёлын үнэт дурсгал "Монголын нууц товчоо" номыг хоймортоо залж, хүндлэн дээдэлж буй айл өрхийг шалгаруулан урамшуулах уралдаан зарлаж нийт 13 материал ирсэнээс 1-р сургуулийн үүдний хоргонд байрлуулсан зураг шалгарч "Хаан төрийн нууц", "Хатан төрийн нууц" номоор шагнууллаа.

Хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог хангах, санаа бодлыг нь сонсож мэдээлэл олж авах, хамгаалуулах, олон нийтийн бүхий л орчинд өөрт хамааралтай шийдвэр гаргахад хариуцлагатай оролцож, хүүхдийн эсрэг далд хүчирхийллийг шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх зорилгоор Зүүнхараа хүүхдийн ордонь хамт олон "Хүүхдээ сонсох өдөр"-ийг ЗДТГ-ын Иргэний танхимд "Хүслийн хөтөч" ХХК болон төвийн 6 сургуулийн 3-12 дугаар ангийн суралцагчдын төлөөллүүдийг оролцуулан нийт 84 сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа.

Хүүхэд, залуусыг "Илтгэх" урлагаар дамжуулан өөрийгөө илэрхийлэх чадварт сургах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэн хөгжүүлж, эх орноо хайрлан хүндэтгэх үзэл бодлыг суулгаж зөв иргэн хүн болж төлөвшүүлэх зорилгоор Мандал сумын Ерөнхий боловсролын сургуулиудын 9-12 ангийн сурагчид болон ЗХПК-ийн 16-18 хүртэлх насны оюутнууд дунд зохион байгуулагдсан "Би Монгол Улсын иргэн" гэсэн сэдэвтэй илтгэлийн тэмцээнд нийт 32 суралцагчид идэвхтэй оролцож өөрийн бэлдсэн илтгэлүүдээ тавьж амжилттай оролцож туршлага хуримтлуулж чадсан. Амжилт гаргасан 11<sup>а</sup> ангийн сурагч Батбаяр, 9<sup>а</sup> ангийн сурагч Сувдэрдэнэ, 11<sup>б</sup> ангийн сурагч Мөнгөнзаяа нарыг өргөмжлөл, медаль, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.

Түнхэл тосгоны довийн хэсгийн 60м урттай автомашины гүүрийг барьж ашиглалтад оруулж, Түнхэл соёлын төвийн барилгын дээвэр, спорт залны гэрэлтүүлэг, агааржуулагчийг засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд 21 аймгийг хамруулсан "орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог идэвхжүүлэх нь" сэдэвт хэлэлцүүлэгт оролцлоо.

Төвийн шугамд холбогдсон, 5м х 6,5м хэмжээтэй агаарын шинжилгээний байрыг барьж ашиглалтад орууллаа.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 38 иргэнд 6,5 га газар өмчлүүлсэн. Газар эзэмшихтэй холбоотой 50 иргэн аж ахуйн нэгжийн асуудалыг бүрэн шийдвэрлэжээ.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд гахай 3764 үхэр 29294 нийт 33059 мал амьтан хамаруулсан. Үхэр ангилалт 700 толгой үхэр хамаруулсан. Малчдын мэдлэгийг дээшлүүлэх туршлага судлах аялалыг зохион байгуулж, цаг үеийн мэдлэг, мэдээллээр хангах, бусад сум орон нутгийн малын арчилгаа маллагаа сайжруулахзагвар фермерийг туршлага судлах аялалд 26 малчин болон мал бүхий өрх оролцсон.

Улаан буудай 5487 га-гаас 8133 тн, төмс 531,94 га-аас 5600 тн, хүнсний ногоо 455 га-гаас 6365,4 тн, тэжээлийн ургамал 132 га-гаас, 3250 тн, хадлан 11400 тн бэлтгэв.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт: Талбай тусгаарлалт хийлгэх 2 нөхөрлөл хүсэлт гаргасаны дагуу АО-7 га нийт 7 га талбайд талбай тусгаарлалт хийж гүйцэтгэсэн. Мод бэлтгэх эрхийн бичиг, хэрэглээ, түлээ: Хэрэглээний эрхийн бичиг 4 аж ахуйн нэгж, байгууллагад 49 иргэнд 58 ширхэг эрхийн бичгээр хэрэглээ 619 м<sup>3</sup>, түлээгээр 835 м<sup>3</sup> нийт 1454 м<sup>3</sup> олгосон байна. үүнээс төрийн сангийн дансанд нийт 4 169 690 төгрөг, ойн ангийн дансанд 214 930 төгрөг тус тус оруулсан. Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ: Гарал үүслийн эрхийн бичиг 17 аж ахуй байгууллагад 84 ширхэг гарал үүслийн бичгээр хэрэглээ 870 м<sup>3</sup>, түлээ 442 м<sup>3</sup> тус тус олгосон. Мандал сум дах Онцгой байдлын хэлтэс болон Дэлхийн зөн ТББ-тай хамтран "Ой хээрийг түймрээс хамгаалах хамтын ажиллагаа" сэдэвт сургалт-зөвлөгөөнийг зохион байгуулж гамшгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гал түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, болзошгүй нөхцөлд авах арга хэмжээ болон түймрийн үед ашиглах багаж хэрэгслийн стандарт хэмжээ зэрэг сэдвээр 2018 оны 11-р сарын 07-ны өдөр Мандал, Баянгол сумын ойн санг гэрээгээр эзэмшигч 12 нөхөрлөл, 27 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 130 хүн хамрууллаа.

### **Орхон сум:**

Сумын Засаг даргын Тамгын газраас хууль сурталчлах ажлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын сургалтыг нийт төр төсвийн байгууллагын төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны А/19 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулагдаж буй "Нэг баг-нэг агт" аяны хүрээнд Бэлэндалай багийн малчин Г.Мөнхтөмөр, С.Сүхбаатар нархил хамгаалах үйлсэд дэмжлэг үзүүлэн Хилийн 0243-р ангид агт, уналгын морь хандивлалаа.

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас өгсөн удирдамжийн хүрээнд 2018 оны 11-р сарын 12-ны өдөр "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээг зохион байгуулж 5-11 ангийн сурагчийн төлөөлөл 35 сурагчид оролцож тулгамдаж буй асуудлаа тодорхойлон санал бодлоо солилцлоо. Тус арга хэмжээнд ЕБС-ийн захиргаа, сумын хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд, сумын хамтарсан багийн гишүүд оролцож хүүхдийн төлөө хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл хүргэж цаашид хүүхдийн төлөө хэрэгжүүлэх ажлын санал солилцож тэдний асуултанд нээлттэй хариулж, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлаа.

Тайлант хугацаанд сумын Засаг даргын 2017 оны А/02 тоот захирамжийн хүрээнд зохион байгуулагддаг төр төсвийн байгууллагын менежрүүдийн ажил төрлийн мэдээ мэдээлэл солилцох, үүрэг чиглэл өгөх уулзалт 2 удаа, ЗДТГ-ын төрийн албан хаагчдын ажил төрлийн яриа 2 удаа зохион байгуулагдаж Засаг даргаас төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч, ЗДТГ-ын төрийн албан хаагчдад салбар чиглэл бүрээр үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-аас 2017-2018 онд хэрэгжүүлсэн "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т хамрагдсан залуу малчин өрхүүдийн туршлага солилцох уулзалт зөвлөгөөнд амжилттай оролцож тэдний боловсруулсан цагаан идээгээр үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

Тус суманд үйл ажиллагаа явуулдаг төр төсвийн 6 байгууллага ААН-д ажилладаг хөдөлмөр эрхлэж байгаа иргэдийн судалгааг гаргахад төрийн албан хаагч 123, аж ахуйн нэгжид 139 иргэн, нийт сумын хэмжээнд 59 аж ахуйн нэгж байгууллагад 262 иргэн ажиллаж байна.

Монгол улсын Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, аймгийн Засаг даргын 2018 оны А/394 дүгээр захирамжийн дагуу 2018 онд ОХУ-д үйлдвэрлэсэн 52 серийн дугаар бүхий "Шүлхий" өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг "Орхон сүрэг" ХХК МЭҮН нь 45 өрхийн 745 тугал, 2055 үхэр, бүгд 2800 толгой малд, "ЭГДЭМ" БГБХН МЭҮН нь 56 өрхийн 601 тугал, 2299 үхэр бүгд 2900 толгой малд, 95 тоорой, 205 том гахай бүгд 300 гахайд тус тус технологит хугацаанд нь төлөвлөгөөний дагуу тарьж гүйцэтгэсэн.

“Орхон” хонины 2018 оны зохиомол хээлтүүлгэнд “СҮЦСАА” аймгийн үржлийн төвийн 420 хонь малчин Ц.Бадрах /Мангиртрейд ХХК/-ын 110 хонь бүгд 520 толгой “Орхон” үүлдрийн эм хонь хамрагдаж хээлтүүлэг 79,5 хувьтай явагдсан.

Аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас хамтран зохион байгуулсан малчдын өвөлжөө, хаваржааны тооллогод сумын хэмжээний 170 өвөлжөөг хамруулж бүртгүүлэн аймгийн тооллогын комисст хүлээлгэн өгсөн.

11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн ажил, мэргэжлээ сурталчлах сарын ажил эхэлж, мэргэжлийн багш нар болон I-XII ангийн сурагчдыг хамруулсан 7 заалт бүхий хүүхэд хөгжүүлж, төлөвшүүлэх хөтөлбөрт ажил зохион байгуулж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд залуу багш нарын заах арга зүй ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, өөрийн туршлагаа бусадтай хуваалцах зорилгоор англи хэлний багш М.Уранмандал 5-р ангийн 24 сурагчид “Parts of the body” сэдэвт “Сайн” хичээлийг зохион байгуулж цахим сангаа баяжууллаа.

Сэлэнгэ аймгийн БСУГ-аас зохион байгуулж буй “Шүд гараа угаах нь эрүүл байхын үндэс-5” аяны хүрээнд тусгайлан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. БСУГ-аас ирсэн гар угаах аргачлалыг үнэлэх хуудсыг анги бүрт байрлуулан, сурагчид өөрсдөө хяналт тавин үнэлэхэд I анги-97,9%, II анги-97.1%, III анги-98.1%, IV анги-98.6, V анги 99.5%-тай үнэлэгдсэн байна. Төлөвлөгөөний дагуу сумын ЭМТ-тэй хамтран бага ангийн сурагчдын шүдний өвчлөлийг оношлуулах үзлэгт хамруулахад шүдний өвчлөлтэй 53 сурагч тогтоогдож дээд шатны эмнэлэгт эмчүүлэх шаардлагатай байгааг эцэг эхчүүдэд зөвлөлөө.

Хүүхдүүдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоог дэмжлэг болгох зорилгоор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Бидний хүүхэд нас” өдөрлөгийг зохион явууллаа. Энэхүү өдөрлөгөөр эцэг эхчүүдэд хүүхдүүдийг стандартын дагуу орчинд тэдэнд олгох мэдлэг, чадвар, дадлын хүрээнд хөгжүүлэн хүмүүжүүлдэг талаар ажлыг сурталчилан ажиллалаа.

Сумынхэмжээнд 98 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн бөгөөд давхардсан тоогоор 120 иргэдийг гэрийн идэвхтэй хяналтанд хамрууллаа.Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байгаа 7 хүүхдийг тогтмол хяналтанд байлган халамжийн үйлчилгээнд хамруулж байна.

“АНТИБИОТИКИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ”-ний 7 хоногийн аяны хүрээнд антибиотик эмийг зөвхөн эмчийн жороор олгох талаар сургалт зохион явуулж, антибиотик эмийг үйлчлүүлэгчдэд хариуцлагатайгаар жор бичиж, зөв хэрэглэх дадлыг эзэмшүүллээ.

Аймгийн ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгын “ЧОНО БА ДОЛООН ИШИГ” дуулалт жүжгийг ЕБС-ийн болон цэцэрлэгийн 180 гаруй хүүхдэд үзүүлж сонирхуулан хамтарч ажиллалаа.

Түүх,соёлын дурсгалт газар болох Хүн чулуун хөшөө, Буган хөшөө, Буган хад, Өгөөмөрийн бичигт хад зэрэг дурсгалуудыг хашаажуулж, хаягжууллаа.

### **Сант сум:**

2018 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан 7 залуу малчин Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан малчдын туршлага солилцох уулзалт өдөрлөг, сүү цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцож 320000 төгрөгийн борлуулалт хийсэн байна. Өдөрлөг арга хэмжээг аймгийн ХХҮГ –аас зохион байгуулж 11 сумын 80 малчин хамрагдсан байна. ХЭДС-ийн жижиг зээлд 2 иргэнийг хамруулж 20 сая төгрөгний санхүүжилтыг орон нутгийн Хаан банкаар олгоод байна.

"MERCY CORPS" ОУБ-ын LTS 2 төслийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэгч салбараас зохион байгуулсан "Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд" /LEGS/, " Амьжиргаа болсон мал сүргийг гамшгаас хэрхэн хамгаалах, гамшгийг эрсдэл багатай даван туулах", Зудын гамшигтай тэмцэх сумын төлөвлөгөөг боловсруулах арга зүй" сэдвээр сургалт мэдээллийн ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд сумын Онцгой болон

гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, малчдын төлөөлөл 20 гаруй хүн хамрагдсан байна.

Бог мал хээлтүүлгийн ажлын явцад хяналт тавьж, хуц ухныг нийлүүлгийн бус үед сүргээс тусгаарлан ялгаж суурилах журмыг дагуу хуц ухна маллах малчдын өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсний дагуу Ивэн багийн хуц ухныг малчин Ишжамцад, Хушаат багийн хуц ухныг малчин С.Энхээ нарт суурилан ялгаж гэрээ хийсэн байна.

"Ногоон алт -малын эрүүл мэнд" төслийн хүрээнд Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн холбоо, Сэлэнгэ аймгийн Бэлчээрийн менежментийн ажлын хэсгээс хамтран зохион байгуулсан бэлчээр ашиглагчдын зөвлөгөөн сургалтанд сумаас холбогдох мэргэжилтэн төлөөлөл хамрагдсан байна.

Сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, ойн нөхөрлөлүүдийн гишүүдийн хамтарсан баг 2 удаагийн хууль бус мод бэлтгэлийн эргүүл хяналтын ажлыг зохион байгуулсан байна.

Хүүхдэд ээлтэй сум орон нутаг болох зорилтын хүрээнд хүүхэд өсвөр үеийнхний оролцоог хангах, санаа бодлыг нь сонсож мэдээлэл олж авах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Хүүхдээ сонсоё" арга хэмжээг зохион байгуулж 6-12 дугаар ангийн 50 сурагч оролцлоо. Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн буюу Засаг дарга ЕБС-ын сурагчдад үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон хүүхэд өсвөр үеийнхэнд зориулж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, хүүхдийн үзэл бодлыг сонсож тэдний асуултанд нээлттэй хариулж тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал бодлоо солилцсон юм.

Арга хэмжээний хүрээнд "Миний мөрөөдлийн Сант" шилдэг илтгэлийн уралдааныг 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж тэргүүн байранд 11а ангийн сурагч Д.Дүүрэнзаяа, дэд байранд 9а ангийн сурагч О.Сэлэнгэ, гутгаар байранд 9а ангийнсурагч Д.Дагвадорж, тусгай байранд 9а ангийн сурагч Ц.Ану, 9а М.Өсөх-ирээдүй нар шалгарсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах тухай 01 тоот албан даалгаварын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн байгууллагаас 100м зайд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг нэг аж ахуйн нэгжид архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдэгдэж сумын Засаг даргын 11 сарын 20-ны өдрийн №415 албан тоот хүргүүлсэн байна.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон шинжилгээ оношлогоо хийлгэхэд дугаар харгалзахгүй үйлчлэх 70-аас дээш ахмад настаны "Хүндлэл" үйлчилгээг бий болгож ажиллах тухай албан тоотыг сумын Эрүүл мэндийн төвд хүргүүллээ. Мөн сумын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг шинэчлэн батлах тухай сумын Засаг даргын захирамжын төслийг боловсруулж нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх талаар ажил төлөвлөөд байна .

"Дэлхийн хүүхдийн өдөр"-ийг тохиолдуулан ЕБС-иас 11 сарын 20-ны өдөр "Эцэг эхчүүдийн уулзалт өдөрлөг" –ийг зохион байгуулж "Үдийн цай" хөтөлбөрт амталгаа хийлгэж, Хүүхэд хамгаалал, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн тухай ойлголт, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" , Хүн худалдаалах гэмт хэргийн тухай, Боловсролын салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүд , эцэг эх багш, сурагчын гурвалсан холбоог сайжруулахад эцэг эхийн оролцоо , үүрэг хариуцлага, ЕБС-ын өнөөгийн үйл ажиллагаа сургалтын чанар сэдвээр сургалт зохион байгуулж арга хэмжээнд 145 иргэн хамрагдлаа.

Сумын ЭМТ-өөс хэвтэн эмчлүүлэгсэд, иргэдийн дунд "Антибиотиктийн зохист хэрэглээ" "Антибиотикийг жорын дагуу хэрэглэе" "Эмийн хор нөлөө", "Эмийг зөвхөн эмчийн заавраар, эмчийн бичсэн жорын дагуу хэрэглэж суръя" зэрэг сэдвүүдээр

мэдээлэл сургалтанд 72 хүн хамруулж 72 ширхэг гарын авлага бэлтгэн тараасан байна.

### **Цагааннуур сум:**

Жил бүр уламжлал болгон тэмдэглэж буй “Ургацын баяр” арга хэмжээг энэ сарын 7, 8-ны өдрүүдэд сумын дүнгээр нийт 37769 га-аас 54088 тонн ургац хураан авсан амжилттайгаар тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ үеэр аймгийн баяр наадамд арслан, начин цол хүртсэн Цагааннуур сумын харъяат аймгийн арслан Б.Орхонбаяр, аймгийн начин Б.Очирхуяг нарт хүндэтгэл үзүүлэх барилдааныг зохион байгуулсан. Мөн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 3125,0 мянган төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Баярын арга хэмжээнд дуучин МУГЖ Батсүх, дуучин Сөрөлт, Түмэн-Өлзий, Ш.Хүрэлбаатар, бяцхан авъяастан Бат-Энэрэл, Авъяаслаг Монголчууд шоуны алтан базрын эзэн Э.Энх-Эрдэнэ нар оролцож ая дуугаа өргөлөө.

Энэ сарын 13-ны өдөр аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу “Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээг зохион байгуулж, нээлттэй ярилцаж хүүхдийн санаа бодлыг сонслоо.

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги, Байгаль орчны албад хамтран зэрлэг ан амьтныг идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Агнуурын бүс нутгуудад биотехникийн зарим арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг “Харгистай баян бүрд” БГБХАН-тэй хамтран хийж гүйцэтгэсэн.

### **Баянгол сум:**

Сумын Засаг даргын тамгын газраас “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг 11-р сарын 01-ний өдөр зохион байгуулж, сумын төр төсвийн байгууллагууд, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд мэдээ, мэдээлэл зөвлөгөө өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258-р тогтоолын дагуу зохион байгуулсан төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх судалгаанд сумын ЗДТГ-ын 20 албан хаагч хамрагдсан.

Тус сум 2018 онд 6321 га-гаас 7249 тонн буюу 1 га-гаас 15,2 цн үр тариа, төмс хүнсний ногоо 150 га-гаас 1945,8 тонн ургац тус тус хураан авч, энэ сарын 23-нд ургацын баяраа тэмдэглэн өнгөрүүлээ.

Хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан сумын онцгой комисс 11-р сарын 21-ний өдөр хуралдаж халаалтын төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж үүрэг чиглэл өгсөн.

“Бороо гоулд” компани Мандал, Баянгол сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Мандал, Баянгол сумдын малчид, фермерийн аж ахуй эрхлэгчдийг Төв аймгийн Баяндэлгэр суманд байгуулагдсан 400 үнээний кластер фермийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлах арга хэмжээг энэ сарын 7-нд зохион байгуулсан бөгөөд тус сумаас 8 фермерийн аж ахуй эрхлэг малчид хамрагдлаа.

Сумын Засаг даргын захирамжаар малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 419 өрхийн нийт 18558 толгой үхэр, 142 толгой гахайнд вакциныг хийсэн. Мөн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт 55878 бод, 89800 бог, 1342 толгой амьтанг тус тус хамрууллаа.

Ойн тухай хуулийн холбогдох заалтын дагуу түлээ бэлтгэх эрхийн бичгийг 8 иргэнд 58 м3 бэлтгэхээр олголоо.

### **Сайхан сум:**

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах, байгууллагынхаа нийт ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Хариуцлагатай хамт олон” аяныг сумын Засаг даргын Тамгын газрын нийт ажилтан, албан хаагчдын дунд

2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн өрнүүлээд байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар байгууллагынхаа албан хаагчдад 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, сум дундын Цагдаагийн хэлтэст 11 дүгээр сарын 05-ны өдөр, байгууллагын дарга, эрхлэгч нарт 11 дүгээр сарын 14-ний өдөр тус тус сургалт зохион байгуулсан ба нийт 130 гаруй хүнийг хамрууллаа.

Номгон тосгоны газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад болон малчид, мал бүхий иргэдэд 2018 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын талаарх гарын авлага, тараах материалыг бэлтгэн тарааж, яриа таниулга хийн, хууль сурталчлан ажиллалаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 66 тоот албан бичгийн дагуу “Айдасгүй нийгэм- хүчирхийлэлгүй гэр бүл” уриан дор өрнүүлж буй “Сайн найз-Сайн хөрш” аяны хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сум дундын цагдаагийн хэлтэс болон аврах, гал унтраах 61 дүгээр ангитай хамтран 52 подвол, 14 шитний өрөөнд хяналт шалгалт явуулсан байна. Шалгалтын явцад насанд хүрээгүй 2 хүүхэд асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүйгээр подволд амьдарч байсныг илрүүлэн эцэг, эхтэй нь холбогдон, уулзаж албан шаардлага өгсөн. Мөн “Бид сайн хөршүүд” бичил хорооллууддын дундах 5 төрөлт нөхөрсөг тэмцээнийг 2018 оны 11 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа. Тэмцээнд нийт 130 гаруй тамирчид оролцож, 153 иргэн ирсэн байна.

“Нэг хүсэл-Нээлттэй хөгжил” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын тэргүүн н.Батбаярыг урьж, 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагынхаа нийт ажилтан, албан хаагчдад болон төр, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт нийт 42 хүнд “Төрийн албаны манлайлал” сэдвээр сургалт зохион байгуулан ажиллалаа.

Сумын Хөтөл 1-р баг, Гавшгай 2-р баг, Номгон 3-р багийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 2018 оны 10-р сарын 24-ний өдрөөс 2018 оны 11-р сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн, 281 өрхийн үхэр-10232, гахай-231, нийт-10463 толгой малыг хамруулсан байна.

Өвс, тэжээлийн будааг сумын өвс тэжээлийн нөөцөд бэлтгэн нийлүүлж, сумын Засаг даргын 2018 оны 10-р сарын 25-ны өдрийн хамтран ажиллах тухай 1/544 тоот албан бичиг төлөвлөн, үр тариа тариалагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тариалан болон өвөлжөө хаваржааны газрын бүртгэл тооллого хийх ажлын удирдамжийн дагуу тус суманд аймгийн ХХААГ, Газрын албадаас холбогдох 7 мэргэжилтэн 2018.11.04-ний өдөр ирж ажиллав.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсэг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийсэн. Энэ ажлын хүрээнд сумын төр, төсвийн байгууллагын шилэн дансны мэдээлэл тайлагналт болон сум орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг хэрхэн мэдээлж, ил тод болгон ажиллаж байгаа талаар мэдээллэл хийж, хамтран ажиллалаа. Төсвийн байгууллагын шилэн дансны судалгааг авч нэгтгэн, аймгийн Аудитын газарт хүргүүлэн ажиллалаа.

Хөтөл 1-р багийн нутаг дахь үйлдвэрийн хортой, хориотой бүсэд зөвшөөрөлгүй амьдарч байсан амьжиргааны түвшин доогуур, зорилтот бүлгийн 5 өрхөд Гавшгай 2-р багийн нутаг дэвсгэр дэх Овоот хороололд мэргэжлийн байгууллагаар кадастрын зураглалыг үнэ төлбөргүй хийлгэн, Газрын тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний 700 м<sup>2</sup> газрын асуудлыг шийдвэрлэж, гэрчилгээг гарган өгч ажилласан.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийтийн хоолны газруудыг туршлага судлуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран тогооч, зөөгчийн туршлага судлуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Сумын хэмжээнд нийт 3 тогооч, 1 зөөгчийг "BROADWAY", "LOS

BANDIDOS”, "ШОКОЛАНДНИЦА /БАБИ САБИ/" , "MOUSTACHE" ресторонуудад тус тус туршлага судлуулан ажилласан болно.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа сумын хэмжээнд 2018 оны 10-р сарын 24-ний өдрөөс 2018 оны 11-р сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд явагдаж Хөтөл 1, 2-р багийн хэмжээнд 1705 өрх хамрагдаж, нэгтгэлийг аймгийн ХХҮГазарт хүргүүлж, 2017-2018 онд малжуулах хөтөлбөрт хамруулсан “Залуу малчдын зөвлөгөөн-2018”-д тус сумаас 2018 онд хамрагдсан малчдын төлөөлөл болох 3 малчин оролцож, боловсруулсан сүү цагаан идээгээр үзэсгэлэн худалдаа гарган 100.000 гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2018 оны ажлын байранд зуучлах үйлчилгээний квот дууссан бөгөөд шинээр үүсэх ажлын байр 90-78 буюу 86.6 хувьтай явагдаж байна.Шинэ ажлын байрны зуучлалыг 11 сардаа багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 5 иргэнд 44.500.000 төгрөгийг Төрийн банк, Хаан банкуудаар дамжуулан олгоод байна.

Нийгмийн Халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас сонгон шалгаруулж, гэрээний үндсэн дээр Дархан-Уул аймгийн “Мөнгөтийн Таг” ТББ нь тендерт шалгарч, ахмад настанд өдрийн үйлчилгээг тус сумын 260 ахмадад ус, түлш, хүнс бэлтгэх, угаалга цэвэрлэгээ хийх зэрэгт туслах, зайлшгүй шаардлагатай асаргаа, сувилгааг явуулын үйлчилгээний хэлбэрээр үр дүнтэй хийж үйлчиллээ.

2018 оны 11-р сарын 01, 02-ны өдрүүдэд УИХ-н гишүүн Д.Эрдэнэбатын санаачлан хэрэгжүүлж буй Сургууль хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Хөтөл ЕБС-ийн багш нар Олон улсын болон үндэсний хөтөлбөрийг хослуулан хэрэгжүүлдэг “Шинэ Эрин”сургууль, мөн гадаад хэл математикийн гүнзгийрүүлсэн сургалттай “Оргил” бүрэн дунд сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж тушлага судлав. Мөн МУБИС-ийн дэд захирал Х.Тамирын зохион байгуулсан “Боловсролын хөгжил, өнөөгийн байдал болон сургалтын чанар, үнэлгээний зарим асуудлууд” сургалтанд хамрагдав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан Олон улсын “Эко сургууль хөтөлбөрийн үндэсний 4-р чуулган “-д Хөтөл ЕБС оролцон ХҮРЭЛ гэрэгэ гардан авлаа.

Бага насны хүүхдийн танин мэдэхүй болон хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих зорилгоор “АЛТАН НАМАР” аялалыг цэцэрлэг бүр зохион байгуулав.

Сайхан сумын албан байгууллагуудын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хуваарийн дагуу хамрууллаа. Нийт 13 байгууллагын 274 ажилчид үзлэгт хамрагдсан байна

“Элэг бүтэн Монгол “ хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирус илрүүлэх үзлэгт орон нутгийн 15-39 насны зорилтот бүлгийн 1557 хүн хамруулахаас 1557 хүнийг буюу 100 хувь хамруулж, В сул эерэг вирустэй 30, В эерэг 64, С сул эерэг 33, С эерэг вирустэй 31, нийт В,С вирустэй 158 иргэн илэрснээс баталгаажуулах шинжилгээнд 134 хүний цусны шинжилгээг авч аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторит хүргүүлсэн байна.

### **Орхонтүүл сум:**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, 2018 оны 258 дугаар албан даалгаварын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд тогтоолын хүрээнд зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албан хаагчдийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгалтанд 13 албан хаагч хамрагдаж хангалттай үнэлгээ авлаа. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга ирэх оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчдаар тус хуулийг судлуулах, сурталчлах ажлыг тайлан хугацаанд зохион байгуулж сумын ЗДТГ, Рашаант тосгоны Захирагчийн ажлын алба, 1,2-р сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүд, Цаг уур зэрэг байгууллагын 120 гаруй ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулсан. Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах журмын төсөлтэй танилцан саналаа хүргүүллээ. Сумын ЗДТГ, Рашаант



тосгоны Захирагчийн ажлын албаны бүтэц орон тооны судалгааг гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлээ.

Төрийн албаны удирдах ажилтнуудын улсын Зөвлөгөөнөөс гарсан Зөвлөмж, Андгайг нийт төрийн албан хаагчдад танилцуулан байгууллага, ажилтан бүр АЗ хэмжээтэй хэвлэж нийтэд ил харагдахуйц газар байрлуулан дагаж мөрдөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд “Шинэ төрсөн эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган 5 эх, хүүхдэд Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өглөө.

2018-2019 оны хичээлийн жилд хүүхэд хөгжүүлэх сургалтын хуваарь, өдрийн дэглэм, сэдэвчилсэн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр шинэчлэх, ЗАН-ын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 24-р цэцэрлэгийн 2018 оны 11 дүгээр сарын хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт урьдчилсан байдлаар 80%-тай байна. Энэ сард бага насны хүүхдийн дунд ханиад их гарч өвчлөл өмнөх сараас их байна. Ерөнхий боловсролын 2-р сургууль нь “Багшийн хөгжил” сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ багш нарын илтгэлийн удалдаан зохион байгуулагдлаа. Илтгэлийн уралдаан 20 багш 10 баг оролцож 1-р байранд Технологийн багш Д.Энхмэнд, газар зүйн багш Ц.Болормаа, 2-р байранд Монгол хэлний багш Г.Нарантуяа гадаад хэлний багш М.Мөнхтуул, 3-р байранд Бага ангийн багш Д.Хишигжаргал хөгжмийн багш Ш.Тэгшжаргал байр тус тус эзэллээ. Сурагчдын гарааны ТТШ-аар багш нарын гарааны үнэлгээг тогтоож дараагийн улиралд тухайн гарааны түвшингөөсөө ахисан эсэхэд дүгнэлт гарган багшийн ажлыг үнэлж дүгнэж байна. Сурагчдын дүнг сурагч нэг бүрийн дүнгийн хуудсанд тавьж эцэг эхэд нь танилцуулан гарын үсэг зуруулсан. Сургалтын үйл ажиллагаагаараа хүүхэд бүрийг хөгжүүлэхэд шат алгасахгүй сургахад анхаарч, хүүхдийг оношилох, багш нар хамтарч хичээлээ бэлдэх заах үйл ажиллагааг эхэлж байна.

### **Баруунбүрэн сум:**

Энэ онд тус суманд 490 өрхийн 169851 толгой мал буюу хонин толгойдшилжүүлснээр 276077 толгой мал өвөлжинө. Үүнд: тэмээ 43, адуу 9815, үхэр 17761, хонь 91468, ямаа 50761 өвөлжих тооцоо гарсан.Тухайн суманд бодын 190, богийн 320 нийт 510 хашаа байгаагаас 15 өрх хашаагаа засаж сэлбэх зорилгоор хэрэглээний мод авч хашаагаа хороогоо засаж сэлбэсэн байна.

Мөн энэ онд бороо оройтож орсонтой холбогдуулан сумын хэмжээнд 1837га талбайг хадаж ногоон тэжээлд боосон бөгөөд зарим аж ахуй нэгжүүд малчдад өгч хадуулснаар сумын малчид болон мал бүхий иргэд 11,0 тн байгалийн хадлан, 2800 тонн ногоон тэжээлийг татан авч бэлтгэлээ хангаснаар малчдын өвөлжилтийн бэлтгэл ажил 85%-тай байна.Сумын хэмжээнд 1300 боодол рульон, 24600 боодол ногоон тэжээлийг бэлтгэж зах зээлд нийлүүлж байна.

Орхон аймгийн Жаргалант суманд 2017 онд малын гоц халдварт шүлхийөвчин гарсантай холбогдуулан хил залгаа өвөлжиж байгаа болон сумын төвийн үхэр, гахайд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хийсэн.Үүнд: Хөшөөт, Хувилгаан, Бор толгой, Будаагийн ам, Тахилт, Наранд өвөлжиж байгаа 101 өрхийн 6096 үхэр, сумын төвийн 2060 үхэр, 34 гахайг хамруулан холбогдох баримт материалыг аймгийн Мал эмнэлгийн газарт хүлээлгэн өгсөн.

Мерси кор олон улсын байгууллагын Ви Ти Нетийн малчдад зориулсанмалын эрүүл мэнд сургалтыг 10-р сарын 24-нд зохион байгуулсан. Сургалтанд 42 малчин хамрагдсан. Сургалтын үеэр малчдад мессежээр цаг агаарын мэдээгээ авах заавар зөвлөгөө өгсөн.

Төл бойжилт, том малын хорогдлын мэдээг аймгийн Статистикийн газарт нэгтгэж гаргасан. Үүнд: 3044 толгой мал хорогдсон. Үүнээс адуу 350, үхэр 540, хонь 1064, ямаа 1100 толгой хорогдсон байна. Үүний 832 толгой нь хээлтэгч мал байна. Сумын хэмжээнд 63051 толгой хээлтэгч төллөж 63051 төл гарснаас 3125 толгой төл

хорогдож 59916 толгой төл бойжиж байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: унага 1686, тугал 4903, хурга 33835, ишиг 19489, ботго 3 бойжиж байна.

Монгол мал үндэсний хөтөлбөр, мах, сүүний анхдугаар аяныг эхлүүлэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11836133 төгрөгийн үнэтэй мал угаалгын зөөврийн тоног төхөөрөмж аймгийн хэмжээнд 8 суманд олгогдсон. Үүнд манайх хамрагдаж авсан.

Энэ онд 9258 га талбайд улаан буудай тариалснаас цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан тарианы болц оройтож подгон түрж ургаснаар 220 га талбайг огт хураах боломжгүй, 1837 га талбай нь тэжээлд шилжснээр 7201 га талбайгаас 8757 тонн буюу 12 цн, 1764 га талбайд тосны ургамлын 954 га талбай нь хураах боломжгүй 810 га талбайгаас 597 тонн тосны ургамал, 90 га талбайгаас 855 тонн төмс, 78,94 га талбайгаас 729,4 тонн хүнсний ногоо тус тус хураан авсан. Улаанбуудайн борлуулалтын хувьд 1400 тонныг ТЭДСанд 5399 тонныг гурилын үйлдвэрүүдэд, 360 тонныг үрэнд 1042 тонн улаан буудай үтрэм дээр байна.

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-тай хийгдсэн гэрээний дагуу үрийн талбайн тусгаарлалтын ажлыг хийж 10 га-д талбайд үрийн арчилгааны ажлыг хийлээ.

Эрдэнэт хотын БСУГ-ын мэргэжилтэн, багш нартай хамтран “Илтгэл бичих арга зүй”, “Багшийн харилцаа” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулахад 30 гаруй багш нар идэвхтэй оролцов. Сумын ЭМТ-тэй хамтран сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 1-12-р ангийн 514 суралцагчийг хамруулан мэдээг БСУГ-газарт мэдээг цахим хэлбэрээр хүргүүлэв.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 38-р тоот тогтоолын дагуу “Сэлэнгэ нутгаа” алдаршуулах түүх, соёлыг таниулах зорилгоор “Сэлэнгэ минь” шүлгийг чээжлүүлэн уран тодоор уншуулах аянд 1-12-р ангийн 506 суралцагч тус шүлгийг анги хамт олноороо идэвхтэй оролцов.

“Урлагийн үзлэг-2018 “ арга хэмжээнд 1-5-р анги, 6-12-р ангийн нийт 550 гаруй багш, сурагчид оролцлоо: Үүнд

Бага ангийн төрөлд:

- ❖ 1-р байрыг Ж.Цолмон багштай 5а ангийн хамт олон
- ❖ 2-р байрыг Ч.Энхжаргал багштай 5б ангийн хамт олон
- ❖ 3-р байрыг Б.Эрдэнэбаяр багштай 4б ангийн хамт олон

Дунд, ахлах ангийн төрөлд:

- ❖ 1-р байрыг Н.Хишигцацрал багштай 11а ангийн хамт олон
- ❖ 2-р байрыг Б.Батцэцэг багштай 10а ангийн хамт олон
- ❖ 3-р байрыг Б.Чимгээ багштай 6а ангийн хамт олон

тус тус шалгарч батламж, зааланд тоглох эрхийн бичгээр шагнаж урамшуулав.

“Сурагчийн баримтлах ёс зүй”-н сургалтыг 3-12-р ангийн сурагчдыг хамруулан зохион байгуулахад нийт 360 сурагчид хамрагдлаа.

Эко сургуулийн дэмжигч байгууллагын 3-р шатны сургалтанд 5-н хүний бүрэлдэхүүнтэй оролцож сургуулийн нийт багш, ажилчдад сургалтыг зохион байгуулахад нийт давхардсан тоогоор 50 багш, ажилчид хамрагдлаа.

Сургуулийн эцэг, эхийн зөвлөлтэй хамтран “Цахим орчинд соёлтой оролцоё” сургалтыг зохион явуулахад 8а, 8б, 9а, 9б, 11а ангиудын 85 суралцагч, эцэг эхийн төлөөллийг хамруулав.

Энэ сард манай цэцэрлэгт хамрах сургах тойргийн 3200 хүүхэд хамрагдахаас 2810 хүүхдийг 87,8%-тай хамрагдуулан ажиллалаа. Багш, туслах багш нар “Гэр бүл” сэдвийн хүрээнд зориуд зохион байгуулах үйл ажиллагаандаа нийт 120 төлөвлөлт батлуулан 72 ширхэг том үзүүлэн, Тоо тоолол, Хэл яриа болон бусад сургалтанд хэрэглэх зорилгоор 215 ширхэг тарааж өгөх материал хийж ашиглаж байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх хүрээнд энэ сард хүүхдийн хэл яриаг зүгшрүүлэх болон ардын зүйр үг, түргэн хэллэгийг “Хэн зөв тод хэлэх вэ?” сэдэвт аяныг Дунд, Ахлаха, б, Бэлтгэл а, б, бүлгийн хүүхдүүдийн хүрээнд зохион явууллаа.

## **Жавхлант сум:**

Тайлант сард Засаг даргын зөвлөлийн хурал 1, байгууллагын өргөтгөсөн шуурхай хурал 3, албан хаагчдын хурал 1 удаа хуралдлаа.

Сумын ИТХ-ын ээлжит хуралдаан 2018.11.22-ны өдөр хуралдаж сумын 2019 оны газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар өмчлүүлж, эзэмшүүлэх газар, аж ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулж, эзэмшүүлэх газар, ХАА-н барилга байгууламжийн газар, хот тосгоны газар, ой болон усан сангийн газар гэж ангилал тус бүрээр зориулалт, байршил хэмжээг тусган 5 бүлэг 24 зүйлийн асуудлыг хэлэлцүүлэн батлуулснаар иргэн аж ахуйн нэгжид газар ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх үндсэн чиглэлтэй боллоо.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу санал боловсруулан сумын хэмжээнд дагаж мөрдөх газрын үнэлгээ, төлбөрийн бүсчлэлийн хэмжээг 0,1-1,0 хувь гэсэн хязгаарт багтаан шинэчлэн тогтоолоо.

Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржилд ашиглаж байгаа Ангус үүлдрийн бухыг 1-р багийн 2 иргэнд 1 жилийн гэрээгээр хүлээлгэн өглөө

Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга, төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар томилогдсон ажлын хэсэг тус суманд 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ирж ажиллалаа. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгалтанд сумын ЗДТГ-аас 12 төрийн жинхэнэ албан хаагчид оролцож хуулийн болон компьютерийн мэдлэг шалгах шалгалтанд хамрагдлаа.

Сумын ИТХ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран "Иргэдээ сонсоё" уулзалтыг сумын төвийн 1, 2-р багийн иргэдийн дунд зохион байгууллаа. Мөн төр төсвийн байгууллагад ажиллан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явцын талаар мэдээлэл хийж зөрчлийн тухай хууль хүүхдийн эрхийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 11-р сарын 13-15-нд Бумбат 1-р багийн малчин айл өрхийн өвөлжилтийн бэлтгэл байдалтай танилцаж, цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэн ажиллалаа.

Шинэ үндсэн хууль батлагдсаны өдрийг угтан Монгол улсын Их Хурлын даргын ивээл дор жил бүр зохион байгуулагддаг сумын аварга шалгаруулах Шатрын тэмцээнийг зохион байгууллаа.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагаас зохион байгуулсан "Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн сургалт, дунд хугацааны үнэлгээ хийх олон улсын баг Ерөө, Шаамар, Жавхлант сумын иргэдийн хурлын төлөөлөгч нарт сургалт ярилцлагыг зохион байгуулж үнэлгээ хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүүжилтээр сумын эрүүл мэндийн төвд 3 хүний бүрдэхүүнтэй эмч нарын баг ирж эрүүл мэндийн даатгал төлдөг иргэдэд үнэ төлбөргүй эмчилгээ оношилгоо хийж нийт 250 иргэн хамрагдлаа.

11-р сард ахмад настанд зориулсан өдрийн үйлчилгээг "Мөнгөтийн таг" ТББ-аас 2 өдөр 80 ахмадыг хамруулж даралт, сахарын хэмжээг үзэн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулж, массаж, арьс арчилгаа, төөнүүрэн эмчилгээ зэрэг үйлчилгээг үзүүлээ. Мөн байнгын асаргаанд байдаг 5 ахмадад гэрээр өдрийн үйлчилгээг үзүүлээ. Амьжиргааг дэмжих зөвлөл хуралдан 1 өрхөд гэрийн мөнгө олголоо. Хугацаагүй хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр авдаг 10 иргэний материал аймагт дахин хяналтанд орлоо.

Газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг туслалцаатайгаар "Алтан намар-2018" ургацын баярыг амжилттай зохион байгууллаа. Баярын арга хэмжээний үеэр тэргүүний шилдэг тариаланч, ногоочин, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан шагнаж урамшууллаа. Энэ үеэр сумын бүх аж ахуй нэгж, төр төсвийн байгууллага, баг, ТББайгууллага, ногоочид, иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулав.

Сумын нутаг дэвсгэр болох Моностой 2-р багийн Цагаан даваанаас нийт 58 иргэн 232 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг авч өвөлжилтийн бэлтгэлээ

хангаад байна. Мөн түлээний мод тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээг 5 иргэнд олгож хяналт тавин ажиллалаа. Ерөө бүсийн сум дундын Ойн ангиас тус сумын нийт 51 иргэн 204 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материал тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээг 51 иргэн авсан байна.

### **Сүхбаатар сум:**

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Улсын тэргүүний 13-р сургуулийн дэргэдэх “Ирээдүй” ширээний теннисний клуб, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Ивэн бургалтай” ширээний теннисний клубын хүүхдүүдийн хамтарсан нөхөрсөг бэлтгэл сургалт, уулзалт, тэмцээн зохион байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 212 тоот албан бичиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг, Биеийн тамир спортын тухай хууль, чийрэгжүүлэх бялдаржуулах үйлчилгээ 20055538 стандартын хавсралтаар батлагдсан “Хүн амын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын сарын аяны хүрээнд 5-60 насны 1341 иргэнийг хамрууллаа.

УИХ-ын гишүүн, Монгол улсын 29 дэх Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын нэрэмжит “СЭЛЭНГЭ ЛИГ-2018” спортын наадам 2018 оны 11 дүгээр сарын 3, 4-ний өдрүүдэд Буянт ухаа спорт ордонд зохион байгуулагдсан бөгөөд энэхүү тэмцээнд 17 сум 6 тосгоны баг, тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, Сүхбаатар сумын 16 багийн 96 тамирчин оролцож, багийн нийлбэр дүнгээр дэд байранд шалгарлаа.

Сүхбаатар сумын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 11 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус тэмцээнд 18-аас дээш насны спортын цол зэрэггүй эрэгтэй-16, эмэгтэй-4 шатарчин оролцож, оюун ухаанаа сорьлоо. Тэмцээний эмэгтэй төрөлд тэргүүн байр Ц.Оюунжаргал, дэд байранд Л.Нямдорж, гутгаар байранд Ж.Мөнхзул, эрэгтэй төрөлд тэргүүн байранд С.Сундуй, дэд байранд С.Дашпүрэв, гутгаар байранд Ц.Буриад нар шалгарлаа.

Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдрийг тохиолдуулан хүүхэд өсвөр үе, залуучуудын дунд сэтгэцийн эрүүл мэндийг дээшлүүлэх, амьдралын зөв дадал, хэв маягийг уриалан сурталчлах зорилгоор ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд “Эрүүл амьдрал надаас эхтэй-Амгалан тайван амьдралын төлөө” сэдэвт дэвжээ тэмцээнийг Сүхбаатар сумын ЗДТГ, “Сэлэнгэ аймгийн Залуу эмч нарын холбоо” ТББ, Нэгдсэн эмнэлэг, Сэтгэцийн поликлиник хамтран зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын санал, санаачлага, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг, оношлогоо, хүн амын эрүүл мэндийн цахим сан үүсгэх ажил Боргүвээ 5 дугаар баг дээр зохион байгуулагдлаа. Энэхүү үзлэгт нийт 987 иргэнийг хамруулж, 648 иргэнийг цахим санд бүртгэсэн.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйлажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Эрүүл хүүхэд-Сэлэнгийн ирээдүй” уриан дор хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн 4 багийн 16 эмч, мэргэжилтнүүд 2018 оны 11-р сарын 12-наас 20-ны өдрүүдэд Сүхбаатар сумын нийт цэцэрлэгүүдэд хийлээ. Тус урьдчилан сэргийлэх үзлэгт хүүхдийг эрүүл мэндийн ерөнхий үзлэг болон амны хөндий, чих, хамар хоолойн эмчийн үзлэг оношилгоо, бие бялдын өсөлт, хөгжилтийн түвшинг тогтоох, хөвгүүдийн үзлэг, цагаан хорхойн шинжилгээ хийж, эрүүл мэндийн сургалт мэдээлэл өгч. Эрүүл мэндийн мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлуудыг зохион байгуулж, 1400 гаруй хүүхдийг хамруулсан..

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, бие бялдарыг чийрэгжүүлэх, эв нэгдэлтэй, хамт олонч нөхөрсөг харьцаа, хувь хүний төлөвшлийг батжуулах, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор ХБИ-ийн эрхийг хамгаалах өдрийг угтан спортын 5 төрөлт Шатар, Ширээний теннис, Шидэт таваг, Гар бөмбөг, Дардас зэрэг тэмцээнүүдийг 2018 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Ерөнхий боловсролын 3-р сургууль дээр зохион байгууллаа. Тэмцээнд 6 багийн 86 иргэн хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Германы хамтын ажиллагааны GIZ төсөл, ADRA Монгол ОУБ-ын хөтөлбөрөөс зохион байгуулсан “ Органик хөдөө аж ахуйн суурь мэдлэг олгох сургалтыг 11 сарын 12-14-ний өдрүүдэд УБ хотод зохион байгууллаа. Уг сургалтанд ХХААХҮЯ ,Сэлэнгэ аймгийн ХХААГ-ын мэрэгжилтэн, Сэлэнгэ аймгийн 11 сум 1 тосгоны газар тариалан хариуцсан мэргэжилтэн болон төсөлд хамрагдсан дундын болон анхан шатны хоршооны гишүүд хамрагдсан. Сургалтаар органик хөдөө аж ахуй гэж юу болох, түүнийг хөгжүүлэх шалтгаан, ая холбогдол, Монголд хэрэгжиж буй холбогдох хууль, журам, өрхийн аж ахуй, зөгийн аж ахуй, сүү цагаан идээний үйлдвэрлэл, нийслэл хот орчимд агробизнес эрхэлж буй туршлага зэрэг мэдлэг мэдээлэл олгогдож оролцогч бүр тодорхой ойлголт мэдлэгтэй болсон байна.

Сүхбаатар сумаас Зөгийн аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Мөнх цовдон хоршоо, газар тариалангийн чиглэлээр нэг хоршоог нэмж төсөлд хамруулахаар боллоо.

Европын Холбооны SECIM төслөөс Хүлэмжний аж ахуйн сургалтанд 2 иргэнийг хамрууллаа. Уг сургалтын үеэр УИХ-ын гишүүн Н.Оюундарь Сүхбаатар сумын ногоочдын бүлэгт өвлийн хүлэмж авах санхүүжилтийг шийдвэрлэж өгөхөөр боллоо.

Ус цаг уур Орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэл, ердийн галлагаатай 10 кВт хүртэл хүчин чадалтай зуух эзэмшигчид, усан халаалтын 11-100 кВт хүртэлх хүчин чадалтай зуух, Дулааны цахилгаан станцын болон усан халаалтын 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуухнуудын судалгааг баг тус бүрээр гаргаж хүргүүлээ.

Сэлэнгэ сум дундын Ойн ангитай хамтран Тужийн нарсны ой цэвэрлэгээний ажилд 8 багийн 40 иргэнийг хамруулан оролцуулж байна. Мөн Ерөө, Хүдэр сумдаас гэрээний дагуу түлшний модны гоожинг олгож эхэлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Жижиг зээлийн зарыг иргэдэд Миний монгол болон СБ сумын Цахим хаяг болон баг тус бүрт зарыг хүргүүлэн ажилласан. Тус жижиг зээлэнд хамрагдах хүсэлтэй иргэдийн төслийг ажлын хэсгийн хурлаар оруулан дэмжүүлж Хаан болон төрийн банкуу 9 иргэн аж ахуй нэгжийн материалыг дэмжсэн бичгийн хамт хүргүүлэн ажилласан.

Хөтөлбөрийн хүрээнд нийтийн хамарсан ажил зохион байгуулан ажилд Ногоон байгууламж нэмэгдүүлэх явган замын хавтан тавих ажлыг 11 иргэнээр 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэн 1120,0 төгрөгийн санхүүжилт гарган хамруулсан.

2018 оны 11 сард Сүхбаатар сумын Баянхан 4-р багт орших нурсан гүүр засварлах багт ан цав үүссэн замын шороог дүүргэх ажил хийж гүйцэтгэсэн. Орхон 6-р багийн нутаг дэвсгэр дэх замын шороог дүүргэх ажилуудыг хийж гүйцэтгэсэн. Буурхээр 8 дугаар багийн нутаг дэвсгэр дэх хөвөн ихээр гаргадаг улиас модыг тайрч цэгцэл ажлыг Бүтээгч бүлгийн 8 иргэдийг ажлын байраар ханган ажиллалаа. Уг ажлыг хийснээр 18 улиас мод ухаж устган цэвэрлэх, 400м<sup>2</sup> талбай бүхий газрыг тэгшлэж ажилласан. Мөн нийтийн эзэмшлийн талбайн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт хаях, ажлыг иргэдээр, 10 хоногт багтаан дуусгаж ажилласан. Мөн 5,0 сая төгрөгт багаж тоног төхөөрөмж авсан. Тоног төхөөрөмж авсанаар ажлын бүтээмж дээшилж ажиллах боломж ихээр бий болж байна.

### **Түшиг сум:**

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ургацын баяр-2018” арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 17-нд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “Эрүүл хүнс” эссэ бичлэгийн уралдаан, “Гар зургийн уралдаан”, иргэдийн дунд “3х3 сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулж, үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

“Иргэдийн дунд “Авьяаслаг, Спортлог-Түшигчүүд” урлаг, спортын арга хэмжээг хуваарийн дагуу явуулж Жаргалмандах 1-р баг болон Ар нуга 2-р багийн хэсгүүдийн дунд зохион байгууллаа.

2018 оны 11-р сарын 06-нд “Хүүхэд Монголын баялаг” төслийн төрийн бус байгууллагын лектор Ш.Алтанцэцэг төр төсвийн байгууллагын албан хаагчид болон

аж ахуйн байгууллага иргэдэд “Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан ба нийт 116 иргэн хамрагдсан.

Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг эхний 11-р сарын 20-ны байдлаар төлөвлөгөө 95763,2 мянган төгрөг бол гүйцэтгэл 63446,4 мянган төгрөг буюу 66.2%-ийн биелэлттэй байна. 2018 оны орон нутгийн орлого 11-р сарын 20-ны байдлаар төлөвлөгөө 190654,9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 174297,5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 91.4%-ийн биелэлттэй байна.

Тус сумаас Зүүнбүрэн сумын иргэдийн түлээний мод бэлтгэх гэрээний дагуу мод бэлтгэлийн ажил явагдаж байна. 2018 оны 11-р сарын 25-ны байдлаар 410 м3 түлээний мод бэлтгэсэн байна.

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангиас 2 байгаль хамгаалагч, 1 аж ахуйн нэгжид тус бүр 1 үлээгч багаж өгснийг хүлээн авсан.

2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын байршлыг GPS-ээр координатыг авч зурагт оруулж, сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын тоот захирамжаар байгуулан ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Мөн Засгийн газрын Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл /бүс/, суурь үнэлгээ ,газрын төлбөрийн хэмжээ шинэчилэн батлагдсан №182 тоот тогтоолын хэлэлцүүлэгийг БИНХ-аар хэлэлцүүлсэн байна.

Малчдын саналд тулгуурлан хээлтүүлэгч малыг малчин иргэнээр маллуулж, тухайн иргэнийг малжуулах гэрээ байгуулан иргэн Дамдинсүрэн, Д.Оюунбат нарт 112 малчин өрхийн 200 гаруй хуц, ухныг маллуулахаар шийдвэрлэсэн.

Малчин болон мал бүхий өрхийн бүртгэлийн гэрчилгээг тараан ажиллаж байна.

“Монгол бахархлын өдөр”-т зориулж сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргасан ба ерөнхий боловсролын сургуулийн 6-12-р ангийн сурагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулж ажилласан.

Бүжгийн дугуйланг хичээллүүлж эхэлсэн ба долоо хоног бүрийн лхагва, пүрэв гарагт 1-5-р ангийн сурагчдыг, мягмар, баасан гарагт 6-9-р ангийн сурагчдыг хамруулан нийт 35 сурагч хамрагдсан ба шинээр 5 бүжиг бүжиглэж сурсан байна.

Авьяаслаг Монголчууд тэмцээний оролцогч Т.Ганбүргэдийн “Хошин элэглэлийн амьд шоу” тоглолт тоглогдож нийт 120 гаруй иргэн үзэж сонирхсон.

2018 оны 10-р сарын 25-нд улиралд 1 удаа зохион байгуулдаг “Эцэг эхийн цуглаан”-ыг зохион байгуулж, сургуулийн захирал Х.Бямбацоо “Багшийн ёс зүйн дүрэм”, бага боловсролын сургалтын менежер П.Оюунжаргал “Суралцагчийн мэдлэг, чадварын ахиц, үнэлгээ”-г давхардсан тоогоор 112 эцэг эхчүүд багш, ажилчдад танилцуулсан.

“Эерэг болгоё” аянд нэгдэж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус аяны хүрээнд 14 бүлгийн 328 сурагч болон эцэг эхчүүдэд “Хүүхдэд хэлж болохгүй 9 зүйл” нугалбарыг тараан өгч ажилласан.

Монгол улсын ардын багш, Монгол улсын гавьяат дасгалжуулагч академич, профессор, олон улсын хэмжээний мастер Д.Банди агсны нэрэмжит 2018 бага насны боксын улсын аварга шалгаруулах “Олимдын гараа” тэмцээнд 7а ангийн сурагч Н.Төр хүрэл медаль, 7а ангийн сурагч Б.Мөнх-Эрдэнэ мөнгөн медаль, ба ангийн сурагч Б.Заяа нар хүрэл медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.

Сургуулийн 20 дугуйлан, секцэнд нийт 253 сурагч үнэ төлбөргүй хамрагдан хичээллэж байна.

Товлолт дархлаажуулалтанд 20 хүүхдийг 100% хамруулсан ба эрүүл мэндийн төвийн эмч ажилчид болон 12 жирэмсэн эхчүүдийг томуугийн вакцинд хамруулсан.

Элэг бүтэн Монгол-2 хөтөлбөрийн хүрээнд зорилтод 15-39 насны 439 хүнийг 100% хамруулж мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь өгсөн. Элэгний С вирус эерэг 27, В вирус эерэг 24 хүнийг аймгийн Гэрэл лабораторит тоолох шинжилгээнд хамруулсан.

Антибиотикийн талаарх мэдлэг хандлагыг дээшлүүлэх 7 хоногийн аяныг 11 сарын 12-18-ны өдрүүдэд зохион байгуулж төр төсвийн болон ард иргэдэд сургалт хийж гарын авлага тараан ажилласан.

## Хушаат сум:

Ургац хураалтын эцсийн мэдээгээр нийт 11990 га, үүнээс үр тариа 9534 га, буудай 8434 га, овьёос 475 га, тосны ургамалт 2336 га-д тариалж, үр тариа 1 га-гаас 20.9 цн буюу 18183.0 тн үр тариа, тосны ургамал 1 га-гаас 14.3 цн буюу 1609.0 тн хураан авлаа. Төмс хүнсний ногооны ургац хураалтын мэдээгээр 9 ААН, иргэд 233.5 га-д тариалан төмс 1 га-гаас 178.6 цн буюу 4170.0 тн, хүнсний ногоо 218.5 га-д тариалж 1 га-гаас 142.7 цн буюу 3118 тн хураан авсан.

Хушаатын мэдээ сонины энэ удаагийн дугаарт газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд, үзэсгэлэн худалдаанд идэвхитэй оролцдог хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг сурталчилах арга хэмжээ авч, үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, танилцуулгыг нийтэллээ.

Сумын ургацын баярыг тэмдэглэн энэ оны газар тариалангийн үйлдвэрлэлийн шилдэгүүдээ тодруулан шагнаж урамшууллаа. Нэгж талбараас хамгийн их үр тарианы ургац хураан авсан аж ахуйн нэгжээр 838 га-д улаан буудай тариалж 2956,0 тн ургац хураан авч 1 га-гаас 35,3 цн улаан буудай хураан авсан амжилтаар "Момоагро" ХХК, нэгж талбараас хамгийн их төмс хураан авсан аж ахуйн нэгжээр 46 га-д төмс тариалж 1285,0 тн төмс хураан авч 1 га-гаас 279,3 цн хураан авсан амжилтаар "Элит үр" ХХК, нэгж талбараас хамгийн их төмс, хүнсний ногоо хураан авсан аж ахуйн нэгжээр 88 га-д хүнсний ногоо тариалж 1450,0 тн ургац хураан авч 1 га-гаас 164,8 цн ургац хураан авсан амжилтаар "Шандас өгөөж" ХХК, "Хамгийн их төмс хүнсний ногоо хураан авсан иргэнээр 20 га-гаас 70 тн ургац хураан авсан амжилтаар М.Баярхүү, "Хамгийн олон төрлийн хүнсний ногоо тариалсан иргэнээр 2 га-д 6 төрлийн хүнсний ногоо тариалж 43,0 тн хүнсний ногоо хураан авсан амжилтаар иргэн Б.Атарчимэг, "Хамгийн их үр тарианы ургац хураан авсан механикжуулагч /НИВА"-аар 365 га талбайгаас 7685,0 цн ургац хураан авсан амжилтаар "Ар Сэвд Могойт" ХХК-ий механикжуулагч Б.Сэдбазар, "Хамгийн их үр тарианы ургац хураан авсан механикжуулагч /ЖонДеер/ "-аар 562 га талбайгаас 19700.0 цн үр тариа хураан авсан амжилтаар "Момо агро" ХХК-ий механикжуулагч Д.Эрдэнэбаатар, "Хамгийн өндөр ургацтай нэгж талбай" -гаар 67 га-гаас 253 тн, 1 га-гаас 37,7 цн ургац хураан авсан амжилтаар "Момо Агро" ХХК, "Газар тариалангийн үйлдвэрлэлийн шилдэг үйлчилгээний ажилтан"-аар 1170,0 тн улаан буудай ялган сортолж улсад тушаасан амжилтаар "Ар Сэвд Могойт" ХХК-ий үтрэмийн ажилтан Д.Нямрагчаа, "Нийгмийн хариуцлагаа сайн хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж"-ээр сумын нийгмийн асуудал шийдвэрлэх арга хэмжээнд 8,3 сая төгрөг хандивлан сумын харьяат 11 иргэнийг тогтмол ажлын байраар ханган нийгмийн даатгалд хамруулсан амжилтаар "Хайрхан оргилуул" ХХК, "Хамгийн их хадлан бэлтгэсэн иргэн"-ээр 260,0 тн хадлан бэлтгэсэн амжилтаар Б.Анхбаяр нар шалгарлаа. Энэ үеэр "Хушаатад үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаанд 18 иргэн оролцож бүтээгдэхүүнээ сурталчлан борлуулалт хийснээс гадна хүчит 32 бөхийн барилдаан болон ургацын баярын нэрэмжит ширээний теннисний тэмцээн, шагайн тэмцээнийг зохион байгууллаа.

Төрийн захиргааны албан хаагчдад зориулан "Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга" сургалтыг зохион байгуулж төрийн захиргааны 16 албан хаагч хамрагдлаа. Суманд зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний талаархи мэдээлэл, зарлалыг цахим хуудаст 6 мэдээлэл, fb хуудаст 12 мэдээлэлийг тавьж нийтэд сурталчиллаа. "Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга" сургалтыг сумын Иргэний танхимд явуулан 25 төрийн албан хаагчийг хамруулан явуулж Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуулиудаа судлах, компьютерийн мэдлэгийг дээшлүүлэх хичээлийг явуулан ТАЗ-өөс авсан судалгааны ажилд хамрагдлаа.

Улсын бүртгэлийн үйлчилгээ: төрөлт 5, овог нэр өөрчлөлт 2, эцэг тогтоолт 6, нас баралт 4, шилжин ирсэн 8, явсан 2, иргэний үнэмлэх шинээр 2, сунгалт 4, дахин 2, газрын 14, үл хөдлөхийн 2, нийт 51 бүртгэл хийгджээ.

Цэцэрлэгийн Хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт: 11 сарын 01 нээс 11 сарын 30-ний байдлаар хамран сургалт нийт 2000 хүүхэд хүлээн авахаас 1439 хүүхэд авч ирц 71.9 %-тай байна. Бүлгийн багш нар өдөр бүр эрүүл ахуйн дадал хэвшлийг олгох ажлыг хэвшүүлж байна. Анги бүлгийн агааржуулалтыг сэлгэн, ариун цэвэр,

цэвэрлэгээ үйлчилгээ, хоолой зайлах, өглөөний дасгал хөдөлгөөнийг тогтмол явуулж байна. 11 сарын 23-нд “Хүүхдийн хөгжилд-эцэг эхийн оролцоо” аймгийн эцэг эхийн нэгдсэн зөвлөгөөн боллоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд 1 иргэнийг хамруулж 10 сая төгрөгийг олгон 2 шинэ ажлын байр гаргалаа. Багийн ИНХ-аар хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ, төсөл хөтөлбөр, СХСангийн зээлийн эргэн төлөлтийн талаар иргэдэд мэдээлэл өглөө. Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн талаар 15 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. “Монгол улсад ажлын байрыг нэмэгдүүлэх нь SECIM” төслийн хүрээнд аймгийн хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн 2 төрлийн судалгаа хийгдэж сумын 474 өрхийн 1117 иргэнийг хамруулж ажил олгогч 5, хувиараа хөдөлмөр эрхлэгч 20, малчин 10, их дээд сургуульд суралцагч 20, ажиллаж байгаа залуучууд 20, ажилгүй 10 иргэн, нийт 85 иргэн хамрагдан ажил олгогчоос түүвэр судалгааг ХХҮГ-т хүргүүллээ.

“Хөгжлийн шийдэл” ТББ-ын 3 шатны сургалт зохион байгуулагдаж 30 иргэн хамрагдаж мэдлэг мэдээлэл авсан. Тус шаталсан сургалтанд хамрагдсан 3 малчин аж ахуйгаа өргөжүүлэх төслийг ТББ-ын багш нартай хамтран боловсруулж жижиг дунд үйлдвэрлэлийн зээлд хамрагдахаар төслөө өгөөд байна.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ Ж.САЙНЦОГ